



**EURASIA CAPITAL  
HOLDING JSC**

"Евразия Капитал Холдинг УЦК" ХК  
**ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТАНИЛЦУУЛГА**

www.eurasiac.com | 7711 9799 | info@eurasiac.com

КОМПАНИЙН НЭР:  
ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО:

"Евразия Капитал Холдинг УЦК" ХК  
2006 оны 04 дүгээр сарын 27-ий өдөр

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР:  
РЕГИСТРИЙН ДУГААР:

9010001120  
2032465

ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Олимпын гудамж, Реженси барилга,  
3-р давхарт 314 тоот

УТАС:  
ИМЭЙЛ:

976 - 77119799  
broker.dealer@eurasiac.com

Улаанбаатар хот, 2015 он



**“Евразия Капитал Холдинг УЦК” ХК-НИЙ НЭМЖ ГАРГАХ ЭНГИЙН  
ХУВЬЦАА**



**200 000 000 ширхэг хувьцаа**

“Евразия Капитал Холдинг УЦК” ХК нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нэмэлт 200,000,000 ширхэг энгийн хувьцааг хөрөнгийн зах зээл дээр гаргаж, төвлөрсөн хөрөнгөөр компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хувьчлагдаж буй компаниудын хувьчлалд оролцох, хадгаламжийн бичиг санхүүгийн хэрэгсэлийг нэвтрүүлэх, шинэ тутам хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийж компанийн цаашдын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилготой болно.




2

*[Handwritten signature]*



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД



ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА НЬ МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД ӨГСӨН МАТЕРИАЛЫН БҮРЭН ХУУЛБАР БӨГӨӨД ТАНИЛЦУУЛГАД ОРСОН МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВИЙГ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ ТАЛ ХҮЛЭЭНЭ.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН “КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ”, “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ” БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ӨӨРИЙН ДҮРМИЙН САНГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙГАА БОЛНО.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДДЭЭ САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХААР ГАРГАЖ БҮЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.






## ТОВЧИЛСОН УГ, НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР



Нэр, томьёо	Тайлбар
Андеррайтер	Хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт босгох зуучлалын үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээ
МХБ	"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
YCS	Үндэсний статистикийн хороо
ҮЦТТТХТ	"Үнэт цаасны телбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
SUN:246	Монголын хөрөнгийн бирж дээр үнэт цаас гаргагчийн үсгэн болон тоон код
IPO	Үнэт цаасаа анх удаа олон нийтэд санал болгох
ХБ	Хадгаламжийн бичиг
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ESOP	Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр




**АГУУЛГА**


“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ УЦК” ХК-НИЙ НЭМЖ ГАРГАХ ЭНГИЙН БҮРЧИЛГЭЭ .....	2
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД .....	3
ТОВЧИЛСОН ҮГ, НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....	4
ХҮСНЭГТ БА ЗУРАГ .....	7
НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ .....	9
1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ .....	9
1.2 ҮНЭТ ЦААС НЭМЖ ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ .....	10
1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА .....	11
1.3.1 КОМПАНИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....	12
1.3.2. БИЗНЕСИЙН ЗАРЧМУУД .....	14
1.4 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	16
1.4.1. ХУВЫЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ .....	16
1.4.2 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ .....	17
1.5 ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТАН .....	21
1.5.1 ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЭЗЭМШДЭГ ХУВЫЦААНЫ ХУВЬ ХЭМЖЭЭ .....	21
1.5.2. КОМПАНИЙН ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТАН, АЖИЛТНУУДЫН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ .....	22
1.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН НИЙТ ХУВЫЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА .....	24
1.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН 5-ААС ДЭЭШ ХУВИЙН ХУВЫЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА .....	24
1.8. КОМПАНИЙН ХУВЫЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ .....	25
1.9 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО .....	27
1.10 КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	29
1.10.1 БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	29
1.10. 2 АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	30
1.10. 3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	30
1.10. 4 СУДАЛГАА .....	31
1.11 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР, САНХҮҮГИЙН БАЙДАЛ .....	33
1.11.1 “Евразия Капитал Холдинг УЦК” ХК-Н ХӨРӨНГИЙН 2015 ОНЫ .....	35
БҮРТГЭЛ .....	35
<b>ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ .....</b>	<b>44</b>
2.1 ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ .....	44
2.2 УРЫД ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ .....	45
2.3 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ШИЙДВЭРИЙН ТУХАЙ .....	45
2.4 НЭМЖ ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУЗ-ИЙН ТОГТООЛ .....	46
2.5 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ШИЙДВЭР, ТОО ШИРХЭГ, ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ .....	47
2.6 ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУДАЛДАН АВАХ ЭРХ .....	48
2.7 ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЖУРАМ .....	50
2.8 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ .....	54
2.9 БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ .....	57
2.9.1 УДИРТГАЛ .....	57
2.9.2 ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ .....	58
2.9.3 КОМПАНИЙН ЕРӨНХИЙ СТРАТЕГИ .....	68



 EURASIA CAPITAL  
HOLDING JSC

2.9.4 АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛЧИЛГЭЭ .....	74
2.9.5 ХАДГАЛАМЖИЙН БИЧИГ .....	77
2.9.6 АЖИЛТНУУДАД ХУВЫЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР .....	85
2.9.7 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	91
2.10 ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА .....	94
2.11 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ .....	105
<b>ГУРАВ. ХӨНДЛӨНГИЙН ДҮГНЭЛТ.....</b>	<b>114</b>
3.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	114
3.2 Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэсэн тухай мэдээлэл, бизнесийн үнэлгээний талаарх үнэлгээний байгууллагын дүгнэлт .....	132
3.3. ХУУЛЬ ЗҮЙН КОМПАНИЙ ДҮГНЭЛТ .....	153
<b>ДОРӨВ. ХАВСРАЛТ .....</b>	<b>184</b>





## Хүснэгт ба зураг

Хүснэгт 1. ТУЗ-ийн гишүүд .....	17
Хүснэгт 2 Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл .....	21
Хүснэгт 3 Эрх бүхий албан тушаалтуудын мэдээлэл.....	22
Хүснэгт 4 Үнэт цаас гаргагч компанийн хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл .....	24
Хүснэгт 5 Компанийн нийт хувьцаа эзэмшигч .....	24
Хүснэгт 6 Нийт арилжсаа .....	30
Хүснэгт 7 Санхүү байдлын тайлан.....	33
Хүснэгт 8 Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	34
Хүснэгт 9 Балансын шинжилгээ .....	34
Хүснэгт 10 Хөрөнгийн 2015 оны бүртгэл, мян.төг .....	35
Хүснэгт 11 Хувьцааны арилжааны судалгаа (2012.06.01-2015.06.01) .....	45
Хүснэгт 12 Татан Төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт .....	55
Хүснэгт 13 Үйл ажиллагааны төлөвлөгөө .....	55
Хүснэгт 14 Хувьцааг зах зээл дээр байршиулах төлөвлөгөө.....	56
Хүснэгт 15 Ханийн өсөлттэй 20 үнэт цаас .....	61
Хүснэгт 16 Ханийн бууралттай 20 үйэт цаас .....	61
Хүснэгт 17 Зах зээлийн таамаглал, тэрбум төгрөгөөр .....	71
Хүснэгт 18 Зах зээлийн таамаглал, тэрбум төгрөгөөр .....	71
Хүснэгт 19 Хөрөнгө оруулалт болон дилерийн үйл ажиллагаа, сая төгрөг .....	73
Хүснэгт 20 Брокерийн үйлчилгээний зорилтот үйлчлүүлэгчид .....	73
Хүснэгт 21 Цаашид баримтлах шимтгэлийн хувь хэмжээний төсөөлөл .....	91
Хүснэгт 22 Орлогын тайлан, төгрөг.....	92
Хүснэгт 23 Хэрэглээний үнийн улсын индекс .....	95
Хүснэгт 24 Мөнгөний үндсэн үзүүлэлт /тэрбум төг/.....	96
Хүснэгт 25 Уул Уурхайн Бүтээгдэхүүний Экспорт .....	98
Хүснэгт 26 Дэлхийн Зах Зээл Дээрхи Ашигт Малтмалын Дундажс Үнэ .....	98
Хүснэгт 27 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, жил бурийн эцэст .....	98
Хүснэгт 28 ACEAH-ы хөгжсүж буй 3 орны харьцуулалт.....	100
Хүснэгт 29 Эрсдэл .....	107
Хүснэгт 30 Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө .....	112
 Зураг 1 Удирдлага, зохион байгуулалт.....	16
Зураг 2 Долларын хани.....	58
Зураг 3 Top-20 Индексийн 2014 оны үзүүлэлт .....	59
Зураг 4 Хувьцааны арилжааны үнийн дүн. 2013-2014 оны харьцуулалт .....	59
Зураг 5 Зах зээлийн үнэлгээ, тэрбум.төг.....	60





Зураг 6 Арилжааны дунгээр зах зээлд эзэлж байгаа хувь. 2014 .....	62
Зураг 7 СВОТ шинэсилгээ.....	63
Зураг 8 Макро орчин .....	64
Зураг 9 Микро орчин .....	65
Зураг 10 Компаний стратеги .....	68
Зураг 11 Үндсэн уйл ажшилагаанаас олох орлого, төгрөг.....	69
Зураг 12 Маркетингийн стратеги .....	70
Зураг 13 Үндсэн уйл ажшилагаанаас олох орлого, төгрөг.....	92
Зураг 14 Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт /сая ам.долл/ .....	94
Зураг 15 Банкны Салбарын Активын Бүтэц.....	96
Зураг 16 Чанаргүй зээлийн үзүүлэлт, салбараар .....	97
Зураг 17 Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, тэрбум төгрөг .....	99
Зураг 18 Барилга угсралт их засварын ажил, төрлөөр .....	99
Зураг 19 Мянмар Улсын Хөрөнгийн Зах Зээл .....	100
Зураг 20 Silkroad Yangon Property Index, ам.доллар/1 м <sup>2</sup> .....	102
Зураг 21 2012 оны Үл Хөдлөх Хөрөнгийн үнийн гүйцэтгэл (Ази Номхон Далайн Бус) .....	102
Зураг 22 Мьянмар Улсад ашиглалтанд орж буй барилга / Сая\\$ .....	104
Зураг 23 2013 оны байдлаарх барилгын салбарын задаргaa .....	104
Зураг 24 Yangon дахь оффисын эрэлт, нийлүүлэлтийн хэрэгцээ 2013 он / сая фут квадрат.....	104
Зураг 25 Эрсдлээс хамгаалах арга зам.....	109
Зураг 26 Эрсдэлийн төрөл болон хамгаалах арга зам .....	112





**EURASIA CAPITAL  
HOLDING JSC**

**НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

**1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**



**КОМПАНИЙН НЭР:** "Евразия Капитал Холдинг УЦК" ХК

**ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО:** 2006 оны 04 дүгээр сарын 27 өдөр

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР:** 9010001120

**РЕГИСТРИЙН ДУГААР:** 2032465

**УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭСЭН ОН САР** 2006 оны 4 дүгээр сарын 27

**ӨДӨР**

**ХАЯГ:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Реженси барилга, 3-р давхарт, 314 тоот

**ИМЭЙЛ:** broker.dealer@eurasiac.com

**ЦАХИМ ХУУДАС:** www.eurasiac.com

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:** Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх





1.2 ҮНЭТ ЦААС НЭМЖ ГАРГАХАД ОРОЛЦОН БАЙГУУЛЛАГУУДЫН  
МЭДЭЭЛЭЛ



АУДИТЫН КОМПАНИ

**“Сүлд Аудит” ХХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж,  
/6-7/ 2 тоот,

Утас : (976) 94054045, (976) 55252512

Факс : (976) 70118016

Email: gundbayar@cpa.mn

[www.suld-audit.mn](http://www.suld-audit.mn)

ХУУЛИЙН КОМПАНИ

**“И Эл Си” ХХН**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг-1, Шонхор Tower, 6-давхар  
(+976) 77118193, 77118194

[www.elclawoffice.mn](http://www.elclawoffice.mn)

ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ

**“Хөрөнгийн Үнэлгээний Төв” ХХК**

Самбуугийн гудамж-11, Засгийн газрын 11-р байр, 1 давхар 1012 тоот, Улаанбаатар,  
Монгол Улс

Утас/Факс: 325127

[www.unelgeeniiituv.mn](http://www.unelgeeniiituv.mn)





### 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч компанийн нэр: "Евразия Капитал Холдинг УЦК" ХК



Үнэт цаас гаргагч компанийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж, Реженси барилга, 3 дугаар давхар, 314 тоот

Үнэт цаас гаргагч компанийн утасны дугаар, цахим хуудас: 976 - 77119799,  
[broker.dealer@eurasiac.com](mailto:broker.dealer@eurasiac.com), [www.eurasiac.com](http://www.eurasiac.com)

Тус компани нь 1996 оны 04-р сарын 28-ны өдрийн 01 тоот тогтоолоор таван хошуу мал, цаа буга, сүүний фермерийн чиглэлээр үндсэн үйл ажиллагаа эрхлэх, хүнсний ногоо, үрслэг тариалалт, үр тариа болон бусад ургамал тариалалт, зочид буудал, амралтын газар, бөөний худалдааны чиглэлээр туслах үйл ажиллагаа явуулахаар "Архуст шунхлай" ХК нэртэйгээр үүсгэн байгуулагдсан.

Анх 100 /Нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 75,874 /Далан таван мянга найман зуун далан дөрөв/ ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд 7,587,400 /Долоон сая таван зуун наян долоон мянга дөрвөн зуу/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байсан.

Санхүүгийн зохицуулах хороо 2013 оны 04-р сарын 10-ны өдрийн 156 тоот тогтоолоор "Архуст шунхлай" ХК-ийг "Евразия Капитал Монголиа" ХХК-тай нэгдэхийг зөвшөөрөн "Архуст шунхлай" ХК-ийн нийт гаргасан 75,874 ширхэг энгийн хувьцааг нэгдэж буй "Евразия капитал монголиа" ХХК-ийн хөрөнгөд ноогдох нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,195,018 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн.

Нэгдэж буй "Евразия Капитал Монголиа" ХХК нь 2008 оны 08-р сарын 25-нд Брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх 3/45 тоот тусгай зөвшөөрөл, 2009 оны 09-р сарын 10-ны өдрийн 184 тоот тогтоолообр Андеррайтерийн үйл ажиллагаа, 2011 оны 07-р сарын 26-ны өдрийн 222 тоот тогтоолоор Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан бөгөөд тус компани нь үнэт цаасны зах зээлд нэр хүндтэй томоохон компаниудын нэг байсан.

Нэгдсэний дараа компани оноосон нэрээ "Евразия Капитал Холдинг УЦК" ХК болгон өөрчилсөн. Мөн компанийн хувьцаа 2,270,892 ширхэг, үйл ажиллагааны чиглэл хөрөнгө оруулагчдад үнэт цаас худалдан авахад нь зуучлах, зах зээлийн үнэ ханш болон хувьцаат компаниудын талаарх мэдээллийг хүргэх, судалгааны бүтээл бэлтгэн боловсруулж хэвлэн тараах, мөн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх, IPO (initial public offering) буюу олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгох үйл ажиллагаа хийх, нэмэлт хувьцаа гаргах ажиллагаа, өрийг хувьцаагаар солих, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах зэрэг болж бүрэн өөрчлөгдсөн.



ҮЦТТХТ-өөс авсан 2015 оны 03-р сарын 23-ны өдрийн үнэт цаас эзэмшигчдийн судалгаагаар тус компани нь 52 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд томоохон хувьцаа эзэмшигчид нь Г.Оюунболд /22,400 ширхэг/, “Урбанресорсес” ХХК /22,000 ширхэг/, Б.Энхжаргал /3,087 ширхэг/, “Евразия капитал лимитед” компани /2,195,018 ширхэг/ нар байна. Бусад 47 хувьцаа эзэмшигчид нь жижиг хувьцаа эзэмшигчид бөгөөд 1 – 350 ширхэг хувьцааг тус тус эзэмшиж байна.

“Архуст шунхлай” ХК нь “Евразия Капитал Монголиа” ХХК-ийг өөртөө нэгтгэснээр хувьцаагаар гэрчлэгдсэн эрхээ хэрэгжүүлээгүй 20-иод жил болж байгаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн чухал арга хэмжээ болсон.

Тус компани нь гадаадын хөрөнгө оруулалтын сан, гадаадын томоохон хөрөнгө оруулагчидтай хамтран ажилладаг. Олон улсад зохион байгуулагддаг, тэр дундаа Хонг Конг, Дубай, Нью-Йорк, Женев зэрэг хотын хөрөнгө оруулалтын чуулга уулзалтуудад байнга оролцдог. Мөн Монголын хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг Бээжин, Шанхай, Хонг Конг, Сингапурт амжилттай зохион байгуулан дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын сангүүд, хөрөнгө оруулагчдыг Монгол руу татах ажлыг амжилттай гүйцэтгэж ирлээ.

“Евразия Капитал Холдинг ҮЦК” ХК-ийн ажилтан ажиллагсдын дийлэнх нь хилийн чанадад, өндөр хөгжилтэй улс орнуудад боловсрол эзэмшсэн, хөгжиж буй болон эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудын зах зээл, Монголын зах зээл дээр арвин туршлага хуримтлуулсан, өндөр мэдлэг боловсролтой.

### 1.3.1 КОМПАНИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Эрхэм  
зорилго

Гадаадын хөрөнгө оруулагчид болон Монголын Хөрөнгийн зах зээлийг холбон ажиллаж, Монголын хөрөнгийн зах зээл дэх хамгийн шилдэг, олон улсын стандартыг хангасан хөрөнгө оруулалтын банк болох

Зорилго

Монголын хөрөнгийн зах зээл болон олон улсын зах зээлийн харилцаанд идэвхтэй оролцон хөрөнгийн биржийн хөгжилд хувь нэмрээ оруулах, хадгаламжийн бичгийг Монголдоо анхлан нэвтрүүлэх

Компаний болон хүний нөөцийн сайн засаглалыг бий болгон





## Зорилго

ажилласанаар хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан, үр өгөөжтэй ажиллах



## Зорилт

Олон улсын стандартад нийцүүлэн гадаадын болон дотоодын үйлчлүүлэгчиддээ хөрөнгө оруулалтын банкны бүхий л үйл ажиллагааг үзүүлснээр үнэт цаасны тэргүүлэгч компани болох

## Ёс зүй

Үнэт цаасны зах зээлд бизнесийн ёс зүйг эрхэмлэн хувьцаа эзэмшигч, харилцагч үйлчлүүлэгчдийнхээ эрх ашгийн нэн тэргүүнд тавин шударгаар өрсөлдөх


## Үйл ажиллагааны үр ашигтай байдал

Компани нь үйл ажиллагааныхаа эрсдэлийг бууруулах болон хамгийн дээд зэргийн чанартай үйлчилгээг харилцагчиддаа хүргэхийн тулд компанийн ашигт ажиллагааг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээд зэргээр хамгаалах



Хөрөнгө

Их хэмжээний хөрөнгийн эх үүсвэр, хөрөнгийн ондор, өгөөж болон  
хөрөнгийн зохистой зөв төвлөрүүлэлт, зарцуулалт



Соёл

Харилцагч болон хувьцаа эзэмшигчдийн төлөө компания чадваржуулах, хөрөнгө оруулалтыг өсгөн нэмэгдүүлэхийн тулд өөрсдийн бухий л мэдлэг боловсрол, ур чадварыг дайчлан шударгаар мэргэжлийн дээд зэргийн ёс зүйтэй ажиллаж заавал дагаж мөрдөх хууль, дүрэм журам, компанийн хэм хэмжээ, соёлыг төлөвшүүлэх

### 1.3.2. БИЗНЕСИЙН ЗАРЧМУУД

Бид үйлчлүүлэгчид, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх, ашиг сонирхолыг үргэлж нэн түрүүнд тавьж ажилладаг. Хэрэв бид өөрсдийн үйлчлүүлэгчид, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалан ёс зүйтэй ажиллах аваас биднийг амжилт үргэлжид дагах болно гэдгийг бидний туршлага харуулсан.

Бидний өмч хөрөнгө бол компаний маань ажилтан ажиллагсад, харилцагчид, хуримтлуулсан туршлага болон нэр хүнд юм.

Бид дагаж мөрдвөл зохих дүрэм журам, ёс зүйн хэм хэмжээ, хуулийн мөн чанарыг бүрэн ойлгон дагаж мөрдөн ажилладагт бидний амжилт оршиж байгаа юм.

Бидний зорилгын нэг бол хувьцаа эзэмшигчдийгээ илүү их өгөөжөөр хангах явдал юм. Ашигтай ажиллах нь их хэмжээний өгөөжийг бий болгох, өөрсдийн хөрөнгийг босгох, бидэнд чухал хүмүүсээ татан өөрсөддөө авч үлдэх нь нэн чухал юм.

Бид өөрсдийн ажил мэргэжлийн ур чадвар, туршлагаараа бахархдаг. Бид хийж буй бүхий л зүйлсдээ тэргүүлэгчид байж зорьж төлөвлөсөндөө хүрэхээр шаргуу ажилладаг. Тиймээс ч магадгүй бид шинэ тутам хөгжиж буй зах зээлд анхдагч болон ажиллаж байгаа ба цаашид ч ажилласаар байх болно.

Бид хамгийн том байхаас илүү хамгийн найдвартай нь байхыг сонгоно.

Бид харилцагч үйлчлүүлэгчидтэйгээ ойр ажиллан тэдэнд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх хамгийн шилдэг, сайн арга замуудыг хайн хамгийн итгэлт зөвлөгч нь байхыг эрмэлздэг.





Хөрөнгийн зах зээлд хамгийн шилдэг ажилтангүйгээр бид хамгийн шилдэг компани болж чадахгүй гэдгийг мэнэ.



Өөр бусад газруудтай харьцуулахад бид өөрийн ажилтан ажиллагсаддаа илүү хурдацтай ахиж дэвших боломжийг санал болгодог. Ажилтны арьс өнгө, шашин шүтлэг, нас хүйс, үндэстний гарал угсаа, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, тахир дутуу байдал, сексийн чиг хандлага зэргийг үл харгалзан ахиц дэвших боломжийг тэгш олгодог.

Бид хийж буй бүхий л зүйлдээ багийн ажлыг үргэлж тодотгодог. Ингэхдээ шинийг санаачлах, бие даан гүйцэтгэх байдал нь үргэлж дэмжигдэж ирсэн бөгөөд багаар ажиллах байдал, чармайлт нь байнга хамгийн сайн үр дүнг бий болгодог гэдгийг бид олж мэдсэн. Компаний болон харилцагчидын эрх, ашиг сонирхол ажилтнуудын хувийн ашиг сонирхолоос ямагт дээгүүр тавигддаг.

Манай компанийн ажилчдын байгууллагадаа оруулдаг хувь нэмэр болон ажилдаа гаргадаг хүчин чармайлт нь бусад байгууллагуудтай харьцуулахад үнэхээр аугаа юм. Бид үүнийг бидний амжилтын салшгүй хэсэг гэж боддог.

Бид байнга өөрсдийн харилцагч үйлчлүүлэгчдийн маш хурдацтай өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагуудыг урьдчилан харахыг хичээдэг бөгөөд тэдгээр хэрэгцээг хангахын тулд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг хөгжүүлэхийг эрмэлздэг.

Бид тогтмол өөрсдийн харилцагчдын маш нууц болон нууцын зэрэглэлтэй мэдээллүүдтэй харьцаж байдгийн хувьд нууцын тухай хууль болон нууц хадгалах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг. Итгэл алдах эсвэл маш нууц мэдээллийг зүй зохисгүй, хайнга ашиглах нь байж болошгүй зүйл юм.

Бидний эрхэлдэг бизнес маань маш их өрсөлдөөнтэй бөгөөд ингэхдээ бид маш идэвхитэйгээр өөрсдийн харилцагчидтай харилцах харилцаагаа өргөжүүлэхийг эрэлхийлдэг. Гэсэн хэдий ч, бид үргэлж шударга өрсөлдөгчид байж хэзээ ч бусад компаниудыг шүүмжлэх, нэр хүндэд нь үндэслэлгүйгээр халдаж, гүтгэх, гутаан доромжлох ёсгүй юм.

Харилцагч, үйлчлүүлэгчид, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг бүрэн дааж найдвартай шударга, үр өгөөжтэй ажиллах нь манай бизнесийн зүрх буюу гол цөм нь юм. Бид хүмүүсээ өөрсдийн хувийн амьдрал болон компанийхаа ажилд аль алинд хийж буй бүхий л зүйлдээ ёс суртахууны өндөр түвшинг баримтладаг байхыг хүсэмжилдэг.



## 1.4 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн тухай хуулийн есдүгээр бүлэг, 59 дүгээр зүйлд заасны дагуу “Евразия Капитал Холдинг УЦК” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Компанийн тухай хуулийн 75.1 зүйлд зааснаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдаж явдаг.

*Зураг 1 Удирдлага, зохион байгуулалт*



### 1.4.1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулдаг. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагаа, тулгарч буй бэрхшээл, цаашдын төлөвлөгөөний талаар хувьцаа эзэмшигчиддээ мэдээлэх, компанийн үйл ажиллагаатай холбоотой чухал асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргах зорилготой ба компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцоггүй хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийн үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэл олж авах, удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд болон хөндлөнгийн аудит, хараат бус гишүүдэд асуулт тавих боломж олгох зорилготой.

Хуралд оролцсоноор хувьцаа эзэмшигчид нь компанийн удирдлагад оролцох эрхээ хэрэгжүүлдэг. Хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг хүлээхийн тулд хурлыг бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах зарчмаар зохион байгуулдаг бөгөөд хувьцаа эзэмшигч бүр хуралд оролцох боломжийг ханган ажиллаж байна.

ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан, ирэх оны төлөвлөгөөг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, нэмэлт үнэт цаас гаргах, хуваах, нэгтгэх зэрэг “Компанийн тухай” хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гаргадаг.

Компани хурал хуралдуулах дэг, хувьцаа эзэмшигчдэд заавал танилцуулах мэдээлэл зэргийг хууль болон журмын дагуу танилцуулж мөрдөн ажиллаж байна.

#### **1.4.2 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна.

ТУЗ нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, гүйцэтгэх удирдлагыг сонгох, ажилд нь хяналт тавих зэрэг үүрэгт ажлуудыг хийхээс гадна Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бусад ажил, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 9-өөс дээш гишүүнтэй байх ба 2 жилийн бүрэн эрхийн хугацаанд үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн ТУЗ-ийн гишүүд нь 2014 оны 03 дугаар сарын 16-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.

*Хүснэгт I. ТУЗ-ийн гишүүд*

Нэр	ТУЗ-ийн гишүүд	Үнэт цаас гаргагчийн хувьцаанаас эзэмшдэг эсэх
Цэрэндорж НЭРГҮЙ	ТУЗ-ийн дарга	0
Гомбо ОЮУНБОЛД	ТУЗ-ийн ердийн гишүүн	22,400
Батбуян ӨЛЗИЙБАЯР	ТУЗ-ийн ердийн гишүүн	0
Энхээ САРАНЧИМЭГ	ТУЗ-ийн ердийн гишүүн	0
Гомбо ЭНХБАТ	ТУЗ-ийн ердийн гишүүн	0
Чадраабалын ГЭРЭЛМАА	ТУЗ-ийн ердийн гишүүн	0
Данзан ҮНЭНБАТ	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0






Ганчимэг ХАЛИУНАА

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Бадамдорж ОТГОНТУЯА

ТУЗ-ийн хараат бус гишүүн



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:

Тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь өөрсдөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй, компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй; төрийн алба хашдаггүй, компанийтай бизнесийн аливаа холбоогүй этгээдүүд болно.

Хараат бус гишүүд төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх, компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах; хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх зэрэг эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилдог.

Ч. Гэрэлмаа нь үнэт цаас гаргагч компанийн ТУЗ-ийн 2014 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хурлын 2014/03/02 тоот тогтоолоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна.

Тэрээр МУИС-ийг Банк санхүүч мэргэжлээр, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг Англи хэлний орчуулагч мэргэжлээр тус тус төгссөн ба одоо үнэт цаас гаргагч компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.



Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх, хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих; хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах; төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилох зэрэг үүргийг хүлээн ажиллаж байна.

#### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХОРООД:**

Үнэт цаас гаргагч компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшигүүлэх хороодтой ба эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдсэн. Энэ нь хуулийн шаардлагыг хангаж байгаа юм.

#### **Аудитын хороо, түүний гишүүд:**

Д.Үнэнбат /Хорооны дарга/

Г.Халиунаа

Б.Өлзийбаяр

Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн бөгөөд нягтлан бодох бүртгэл, аудитийн чиглэлээр мэргэшсэн.

Аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих; дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах; аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах; их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах; компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал зэргээр дүгнэлт гарган төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан ажиллаж байна.






**Нэр дэвшүүлэх хороо, түүний гишүүд:**

Г.Халиунаа /Хорооны дарга/

Б.Отгонтuya

Г.Оюунболд



Үнэт цаас гаргачийн нэр дэвшүүлэх хороо нь компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийн үнэлэх шалгуурыг тогтоох; төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүнд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх; гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах; төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах; төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах зэрэг эрх үүрэгтэйгээр ажиллаж байна.

**Цалин, урамшууллын хороо, түүний гишүүд:**

Ц.Болормаа /Хорооны дарга/

Д.Үнэнбат

Ц.Нэргүй

Цалин урамшууллын хороо нь компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулалт олгох санал боловсруулах, компанийд мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх зэрэг дүгнэлтийг гарган ТУЗ-д тайлагнан ажилладаг.





## 1.5 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

### Гомбын Оюунболд: Гүйцэтгэх захирал

“Евразия Капитал Холдинг УЦК” ХК-ний гүйцэтгэх захирлаар Г.Оюунболд ажиллаж байна. Тэрбээр МУИС-н Хууль Зүйн Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийг тус тус төгссөн. Хууль зүй болон хэл шинжлэлийн бакалавр зэрэгтэй. Тэрбээр өмнө нь Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албанад хяналт шалгалтын мэргэжилтэн, Анод банкны Хууль, Аюулгүйн албанад мэргэжилтэн, “Улаанбаатар Импекс” ХХК-д болон “Улаанбаатар Тоног Төхөөрөмж” ХХК-д Гүйцэтгэх захиралаар тус тус ажиллаж байсан ажлын туршлагатай. Оюунболд нь Англи хэлний мэдлэгтэй. Тус компанид 2008 оноос хойш ажиллаж байна.

#### 1.5.1 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЭЗЭМШДЭГ ХУВЬЦААНЫ ХУВЬ ХЭМЖЭЭ

Тус компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Оюунболд нь нийт 22,400 ширхэг хувьцаа эзэмшдэг болно. (2015 оны 3-р сарын 23-ний тархалтын судалгаа)

Хүснэгт 2 Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл							
№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Албан тушаал	Төгссөн сургууль, мэргэжил	ҮПЗЗ дээр ажил Уйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхний дугаар, дуусах хугацаа	Холбоо барих утас
1	Гомбо	Оюунболд	ХБ7904 0100	Гүйцэтгэх захирал	МУИС-ийн Хуулийн сургууль, Хумуунлэгийн Ухааны Их сургууль	№417	9909 4422
2	Энхээ	Саранчимэг	ЧН8009 2307	Үнэт цаас хөгжлийн менежер, Брокер	ХУИС, КТМС Магистр	№530/1213	9903 1672
3	Батбуян	Өлзийбаяр	ХГ8106 0471	Дотоод хяналтын ажилтан	“Парис 8 Сант Денис Их Сургууль” Бакалавр	№530/1245	9901 8603
4	Гомбо	Эрдэнэбат	ХП7103 0570	Нягтлан бодогч	ХААИС Бакалавр	-	9111 5759





5	Мягмарцэрэн	Буянтогох	УШ8706 2228	Дилер	Рицүмэйкэн ази номхон далайн их сургууль Бизнесийн удирдлага бакалавр	№530/1048 <b>БҮРГ</b> № 01	9906 0415
6	Батгэрэл	Наран цацрал	УК8901 0702	Дилер	МУИС-ЭЗДС Бакалавр	№530/523	9903 1673
7	Хаш-Эрдэнэ	Амгалан билэг	ПЮ08807 3103	Шинжээч	Вэббэр ОУ-ын Их Сургууль, СЭЗДС-ийн Бакалавр	№ 531/34	9406 5661
8	Даваасүрэн	Мөнх- Эрдэнэ	УЮ8903 1252	Шинжээч	МУИС, Санхүүгийн Удирдлагын Бакалавр	№ 531/45	8811 6432
9	Ундармаа	Анар	ХЛ8804 2018	Шинжээч	Хүрээ дээд сургууль, Бориот их сургууль /Англи улс/	-	9995 8282

### 1.5.2. КОМПАНИЙН ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТАН, АЖИЛТНУУДЫН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

*Хүснэгт 3 Эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл*

Төвл хадгала да д	Холбогдох /этгээдүүдийн / эхнэр, нөхөр, хүүхэдг.м./ овог, нэр	Төвлөрсөн Хадгаламжин дахь дансны дугаар	Албан тушаал	Эрх бүхий албан тушаалтан, ажилтны овог нэр
T.Эрдэмцогт /нөхөр/, Э.Төгс-Очир /хүү/	62-11		ТҮЗ-ийн Гишүүн, Гүйцэтгэх захирал	Гомбын Оюунболд
Л.Баярмаа /Эхнэр/ Н.Ананд-Очир /хүү/ Н.Бодьзавья /охин/			ТҮЗ-ийн Дарга	Цэрэндоржийн Нэргүй
B.Батсүх /нөхөр/ Б.Сувд-Эрдэнэ /Охин/			ТҮЗ-ийн Нарийн Бичгийн Дарга	Чадраабалын Гэрэлмаа


Б.Мөнх-Эрдэнэ /Хүү/

Б. Баясан /нөхөр/,  
Б. Ариана /охин/

<b>Энхээгийн Саранчимэг</b>	ТУЗ-ийн Гишүүн, Үнэт цаас хөгжлийн менежер, Брокер		
<b>Батбуянгийн Өлзийбаяр</b>	ТУЗ-ийн Гишүүн, Дотоод хяналтын ажилтан	62-3225	Ц.Батбуян /эцэг/ Д.Батсайхан /эх/
<b>Бадамдоржийн Отгонтуяа</b>	ТУЗ-ийн Гишүүн		С.Батбуян /нөхөр/ Б.Золбаяр /хүү/ Б.Хангал /хүү/
<b>Гомбын Энхбат</b>	ТУЗ-ийн Гишүүн		С.Сарантуяа /Эхнэр/ Э.Энхтувшин /хүү/
<b>Цэрэнгомбын Болормаа</b>	ТУЗ-ийн Хараат бус Гишүүн		Х.Цэрэнбадам /ээж/ Ц.Оюумаа /эгч/
<b>Данзангийн Үнэбат</b>	ТУЗ-ийн Хараат бус Гишүүн		
<b>Ганчимэгийн Халиунаа</b>	ТУЗ-ийн Хараат бус Гишүүн		С.Ганчимэг /Ээж/
<b>Мягмарцэрэнгийн Буяントогтох</b>	Дилер		Ц.Дашдорж/нөхөр/ Д.Доржбал /хүү/
<b>Баттгэрэлийн Наранцацral</b>	Дилер		Б.Элбэгбаяр /хүү/
<b>Хаш-Эрдэнийн Амгаланбилэг</b>	Шинжээч	62-1256	Д.Хаш-Эрдэнэ /эцэг/ Д.Энхээ /эх/
<b>Даваасүрэнгийн Мөнх-Эрдэнэ</b>	Шинжээч	58-111124 /MIBG/	Д.Даваасүрэн /эцэг/ Д.Бадамгарав /эх/
<b>Үндармаагийн Анаар</b>	Шинжээч		Б.Үндармаа /эх/

Эх сурвалж: "Евразия Капитал Холдинг" УЦК ХК, Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа

Нэр	Улсын бүртгэлийн дугаар	Хувьцааны тоо	Хувь
Евразия Капитал Лимитэд	TU-222084	2,195,018	96.66%
Г.Оюунболд		22,400	0.97%
“Урбанресурсес” ХХК	9019052026	22,000	0.96%
Б.Энхжаргал		3,087	0.14%
Бусад		28,387	1.25%



#### 1.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН 5-ААС ДЭЭШ ХУВИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

“ҮЦТТХТ” ХХК-иас 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөр гаргасан Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлээр компаний нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэг 1 хувьцаа эзэмшигч байна. Нийт гаргасан хувьцааны 96.66%-ийг “Евразия Капитал Лимитед” ХК эзэмшдэг бөгөөд үлдэгдэл 3.34%-ийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Компанийн хувьцаа эзэмшигчид бүгд Монгол Улсын иргэд болон аж ахуйн нэгжүүд юм.

*Хүснэгт 5 Компанийн нийт хувьцаа эзэмшигч*

Үзүүлэлт	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Эзэмшигчийн хувь
5-с дээш хувийн хувьцаа эзэмшигч	1 хувьцаа эзэмшигч	2,195,018 ширхэг	96.66%
5 хүртэлх хувийн хувьцаа эзэмшигч	51 хувьцаа эзэмшигч	75,874 ширхэг	3.34%


Эх сурвалж: “Евразия Капитал Холдинг” УЦК ХК,  
Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа

“Евразия Капитал Лимитед” ХК нь 2009 оны 1-р сарын 14-ний өдөр Кэймэн Арапд байгуулагдсан. Тус компани Монгол, Мьянмар, Мозамбик болон Дундад Азийн Фронтиер зах зээлүүдэд төвлөрөн ажилладаг хөрөнгө оруулалтын банк бөгөөд гадны хөрөнгө оруулагчдыг эдгээр улсын уул уурхай, газрын тос, байгалийн хий, банк санхүү, хөрөнгийн зах зээл, үл хөдлөх хөрөнгө болон бусад салбарт хөрөнгө оруулахад нь зуучлан ажилладаг. “Евразия Капитал Лимитед” компани байгуулагдсан цагаасаа хойш Монголын зах зээлд идэвхитэй ажиллаж байна.





TU-222084



### Certificate Of Incorporation

I, MELANIE E. RIVERS-WOODS Assistant Registrar of Companies of the Cayman Islands  
DO HEREBY CERTIFY, pursuant to the Companies Law CAP. 22, that all requirements of the said  
Law in respect of registration were complied with by

EURASIA CAPITAL LIMITED

an Exempted Company incorporated in the Cayman Islands with Limited Liability with effect from  
the 14th day of January Two Thousand Nine

Given under my hand and Seal at George Town in the  
Island of Grand Cayman this 14th day of January  
Two Thousand Nine



Assistant Registrar of Companies,  
Cayman Islands.

### 1.8. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

- Үнэт цаас гаргагч компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:  
Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр  
гаргах үед ТУЗ –өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж  
байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй  
саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх
- ТУЗ –өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа  
эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох  
ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд  
хуваарилаагүй бол алданги төлөхийг шаардах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 – р зүйлд заасан  
журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас  
олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;



- Нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн бэлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүрөөрийн эзэмшиж буй хувьцааг компанийд эргүүлэн авахыг шаардах;
- Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
- Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25% - аас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25% -аас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
- Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрмэнд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- Нэг хувьцаа эзэмшигч туунтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75 -аас дээш хувийг эзэмших болсон эсхүл компанийн төрийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанийд хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй;
- Энгийн хувьцааны 5 -аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 01 – ны дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ –д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;
- Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөргүй хуулбарлан авах;
- Энгийн хувьцааны 10% -аас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;
- Энгийн хувьцааны 10% -аас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахаар ТУЗ –д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалтыг шаардан гаргуулах;
- Компанийн эрх бүхий албан тушаалтан компанийн тухай хууль болон энэ дүрмийн 8.2 –т заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс компанийд хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанийд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
- Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх;

2. Компанийн хувьцаа эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг ~~дангаараа~~ эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;
- Нийт гаргасан хувьцааны 5 –аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшишэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын З хоногийн дотор энэ тухай компанийд бичгээр мэдэгдэх;
- Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийн хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.
- Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль болон давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцоно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан байна.

### 1.9 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Хувьцаа эзэмшигчид нь компанийн хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийхдээ тодорхой хэмжээний орлого олохоор төлөвлөдөг учраас өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчидад зориулж компанийн ашиг хуваарилалтын бодлого, ногдол ашиг хуваарилах ашгийн доод хязгаар, ашиг хуваарилах хэлбэр зэргийг тодорхой журамлаж өгсөн.

Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна. Компани ашигтай ажилласан бөгөөд компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан хөрөнгө оруулалтад зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа үед ногдол ашиг хувиарлана. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

Жилийн санхүүгийн тайланг аудитийн байгууллагаар хянуулан татварын байгууллагад өгснөөс хойш буюу жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг ТУЗ-өөр хэлэлцэн шийдвэр гаргана.

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.





Нийтэд хүргэж байгаа мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхой ~~СОН~~ үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна. Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байхаар зохицуулсан.

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх хугацааг заасан байх бөгөөд энэ хугацаандaa ногдол ашгийг олгох ёстой. Ногдол ашгийг хугацаанд нь бүрэн олгоогүй зэргээр хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл учруулсан, хохироосон гүйцэтгэх удирдлагын ажилтанд хариуцлага хулээлгэх журмыг “Ногдол ашгийн бодлого”-д тодорхой тусгасан.

Ногдол ашгийг олгох хэлбэр нь мөнгөн хөрөнгө, зах зээлд идэвхитэй арилжаалагддаг үнэт цаасны хэлбэртэй байх нь зохимжтой. Хувьцаа эзэмшигч дансны дугаараа албан ёсоор мэдэгдсэн нөхцөлд бэлэн бусаар шилжүүлж болно. Хувьцаа эзэмшигч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд эд хөрөнгийн хэлбэрээр олгож болно.

Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах бөгөөд тайлбартай ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

Компани дор дурьдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилахаар журамласан. Үүнд:


- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгөөс багагүй байх
- Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн эдгээр хувьцааг бүрэн эргүүлэн авсан байх





## 1.10 КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Евразия Капитал Холдинг УЦК” ХК нь үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлүүдийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан бөгөөд олон жил ажилласан туршлагатай мэргэжилтийн бүрдсэн багтай брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн болон судалгааны үйлчилгээг олон нийтэд хүргэдэг.



### 1.10.1 БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Брокерийн үйл ажиллагаа” гэж харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс, түүний даалгавраар үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэх юм.

“Евразия Капитал Холдинг УЦК” ХК нь харилцагчид, хөрөнгө оруулагчидад шаардлагатай мэдээ мэдээллийг үнэн бодитоор шуурхай хүргэн, зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдах үйлчилгээг үзүүлдэг. Бид харилцагчийн даалгаврыг гэрээнд заасан нехцөл, шаардлагын дагуу үнэнч шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж байна. Мөн харилцагчийн даалгаврыг тэргүүн ээлжид биелүүлэх, харилцагчдын захиалгыг, захиалга өгсөн дарааллын дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

Харилцагчтай брокерийн үйлчилгээ үзүүлэх талаар аливаа гэрээ байгуулахаас өмнө сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар урьдчилан мэдэгдэх, эсхүл гэрээ байгуулсны дараа сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухай харилцагчид нэн даруй мэдэгдэх үүргийг хүлээн харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг мөнгөн хөрөнгө, үнэт цаас хадгалах эрх бүхий байгууллагад тусгайлан нээсэн дансанд өөрийн мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас тусад нь байршуулж ажилладаг. Харилцагчийн өмчлөл дэх үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг харилцагч тус бүрээр хөтөлж, бүртгэлийг тогтоосон журмын дагуу харилцагчид танилцуулах, зарим тохиолдолд цахим хаягаар нь илгээх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Хөрөнгийн зах зээлийн талаар дотоодын анхлан хөрөнгө оруулагчдын мэдлэг боловсрол бага байгаа тул компани нь тэдгээрийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шаардлагатай зөвлөгөөг тогтмол өгч сургалт явуулж байна.

#### *Брокерийн үзүүлэлт:*

#### *Хувьцааны арилжаа*

2014 оны жилийн эцсийн байдлаар Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 60.4 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдсан бөгөөд үүнээс тус компани нь 0.7 тэрбум төгрөгийн арилжаа хийж, нийт брокерийн компаниудаас 9 дүгээр байранд орсон.



*Хүснэгт б'Нийт арилжсаа*

Нийт арилжаа, тэрбум төгрөгөөр				Б' 2014
2010	2011	2012	2013	2014
5.5	5.8	1.5	2.2	0.7

### *Засгийн газрын бондын арилжсаа*

Засгийн газрын бонд гэж Монгол Улсын Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жилээс дээш хугацаатай өрийн бичгийг хэлнэ. Засгийн газрын бондыг нэрлэсэн үнээр гаргаж, анхдагч зах дээр арилжаагаар тогтсон үнээр худалдах ба нэрлэсэн үнээр буцаан төлдөг.

Монгол Улсын Засгийн газрын бондын арилжаанд “Евразия Капитал Холдинг УЦК” ХК идэвхитэй оролцдог бөгөөд 2011 онд нийт 450 сая төгрөгийн засгийн газрын бондын арилжаа хийсэн.

#### **1.10. 2 АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Андеррайтерийн үйл ажиллагаа гэж үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авах зэрэг ажиллагаа юм.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгодог андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг компани нь эзэмшидэг. 2014 онд “Дархан Хүнс” ХК-ийн өрийг хувьцаагаар солих, нэмэлт хувьцаа гаргах үйл ажиллагааны андеррайтераар ажиллаж амжилттай хэрэгжүүлсэн. Мөн 2015 онд “Блюскай секьюритиз” ХК-ийн хаалттай хүрээнд хувьцаа нэмж гаргах ажиллагааг амжилттай хийж гүйцэтгэсэн. Мөн “Силк Рөүд Файненс” компанийд 5 сая канад долларын хөрөнгийг амжилттай босгож Канадын бирж дээр бүртгүүлсэн.

#### **1.10. 3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа нь үнэт цаас гаргагчийн нийтэд танилцуулагдсан мэдээлэл дээр үндэслэн судалгаа, шинжилгээг гүйцэтгэх, харилцагчид үнэт цаасыг худалдах, худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар мэргэжлийн зөвлөгөөг төлбөртэйгөөр өгөх ажиллагааг хэлдэг.





“Евразия Капитал Холдинг УЦК” ХК нь хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрлийн дагуу дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын зөвлөлгөө өгөх үйлчилгээг үзүүлдэг. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээнд Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулах, хөрөнгө босгох, компанийн нэгдэх нийлэх, худалдан авах, өөрчлөн байгуулах болон хувьчлах талаар зөвлөгөө өгсөөр ирсэн.

#### 1.10. 4 СУДАЛГАА

Компани нь хараат бус, нарийн нямбай, товч тодорхой макро болон микро судалгааны үйлчилгээг харилцагч болон үйлчлүүлэгч нарт өдөр тутмын арилжааны мэдээ, долоо хоногийн тойм /UB post/ зэрэг мэдээллийг хүргэхээс гадна хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниудын талаарх мэдээлэл, макро болон микро эдийн засгийн судалгаануудыг цахим болон хэвлэмэл байдлаар хүргэдэг.



 EURASIA CAPITAL  
HOLDING JSC




**НИЙТ ӨР ТӨЛБӨР БА  
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ**

**2,074,621,547.76**

**2,558,517,213.13**

**2,548,001,435.70**



*Хүснэгт 8 Орлогын дэлгэрэнгүй тайлан*

	2013	2014	/тогроогаар/ 2015.06.30
<i>Борлуулалтын орлого (цэвэр)</i>	539,398,117.21	7,165,234.22	6,522,086.86
<i>Борлуулалтын ортог</i>	337,400,000.00	0	89,315.61
<i>Нийт ашиг</i>	<b>201,998,117.21</b>	<b>7,165,234.22</b>	<b>6,432,771.25</b>
<i>Хүүний орлого</i>	5,304,823.53	7,540,131.21	988,309.51
<i>Ерөнхий ба удирдлагын зардал</i>	209,518,705.85	248,325,571.11	98,772,062.13
<i>Бусад зардал</i>		5,214,565.12	6,531,367.00
<i>Гадаад валютын ханишийн зоруу</i>	14,764,256.41	5,975,440.05	232,821.06
<i>Санхүүгийн зардал</i>		0	
<i>Бусад орлого</i>		109,316.59	40,000.00
<i>Татвар төлөхийн өмнөх ashiig</i>	<b>12,548,491.30</b>	<b>(232,750,014.16)</b>	<b>(97,609,527.31)</b>
<i>Орлогын татварын зардал</i>	469,384.61	754,013.12	98,830.95
<i>Татварын дараах ашиг (алдагдал)</i>	12,079,106.69	(233,504,027.28)	(97,708,358.26)
<i>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</i>	12,079,106.69	(233,504,027.28)	(97,708,358.26)
<i>Бусад дэлгэрэнгүй орлого</i>	-3,732,179.00		
<b>ОРЛОГЫН НИЙТ ДҮН</b>	<b>8,346,927.69</b>	<b>(233,504,027.28)</b>	<b>(97,708,358.26)</b>

*Хүснэгт 9 Балансын шинэсилгээ*

	2013	2014	2015.06.30
<i>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</i>	248,943,631.01	86,657,100.55	11,138,291.35
<i>Богино хугацаат хөрөнгө оруулалт</i>			
<i>Авлага</i>	42,883,540.42	86,180,200.42	156,998,417.92
<i>Эргэлтийн хөрөнгийн дүн</i>	2,001,778,394.60	2,496,873,092.17	2,491,910,807.42
<i>Бусад санхүүгийн хөрөнгө</i>	1,702,276,910.43	2,316,092,258.77	2,316,002,943.16
<i>Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө</i>			
<i>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</i>	72,843,153.16	61,644,120.96	56,090,628.28
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,074,621,547.76</b>	<b>2,558,517,213.13</b>	<b>2,548,001,435.70</b>



**1.11 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР, САНХҮҮГИЙН  
БАЙДАЛ**

Он... сар  
Хүснэгт № 01 /төгрөгөөр /  
Б/У Санхүү байдлын тайлан  
2015.Н.

Зах зээлийн үнэлгээ бага, зах зээлд оролцогчид цөөн, мөн арилжигдаж буй үнэт цааснууд бодитой санхүүгийн үнэлгээнд суурилаагүй байгаа нь сул тал гэж бид үзэж байна. Сүүлийн жилүүдийн эдийн засгийн удаашралт болон хууль эрх зүйн орчины тогтвортгүй байдал нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд аюул учруулж байна.

#### **Зураг 7 SWOT шинжилгээ**

Давуу талууд	Сул талууд
<ul style="list-style-type: none"> <li>• Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран Монголын хөрөнгийн бирж MIT системийг 2012 онд суурилуулсан</li> <li>• Монголын бүх иргэд Эрдэнэс Таван Толгой компанийн хувьцаа эзэмшигч болсон, цаашид үнэт цаасны зах зээлд оролцох иргэдийн тоо өснө</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зах зээлийн үнэлгээ бага</li> <li>• Зах зээлд оролцогчид цөөн</li> <li>• Компаниудын үнэлгээ бодитой биш</li> <li>• Хөрвөх чадвар бага</li> <li>• Иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг бага</li> <li>• Компаниудын засаглал муу, ил тод байдал</li> </ul>



- Шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлж байгаа. /Кастодиан банкны үйлчилгээ, хэдэг сан гэх мэт/

- дутагдаж байгаа
- Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал чамлаалтай



#### Боломжууд

- Эдийн засаг цаашдаа хурдтайгаар өснэ
- Төрийн мэдлийн аж ахуйн нэгжүүд хувьчлагдана
- Уул уурхайн салбарын өсөлт бусад салбарын өсөлтийг хурдасгана
- Газар зүйн хувьд 2 том түрний дунд оршидог учраас хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэх томоохон боломжтой

#### Аюул

- Хууль эрх зүйн орчин
- Макро эдийн засгийн орчны эрсдэлийн хүчин зүйлүүд
- Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралт болон олборлолт Монголын эдийн засагт хүндэрэл учруулж байна
- Гадаадын хөрөнгө оруулалт эрс буурсан
- Эдийн засаг хямарт олон арван аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалтай болж үүд хаалгаа барьж байгаа нь банкны эрдэл нэмэгдэж санхүүгийн хямрал болох нөхцөлийг үүсгэж байна

## СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Бизнес гадаад орчны шинжилгээ

Эдийн засаг	Технологи	Улс төр - Хууль	Зураг 8 Макро орчин Нийгэм - соёл
<b>ДНБ-ний цэвэр өсөлт 2014 онд 7.8%-д хүрсэн. Өмнөх жилүүдтэй харьцуулбал ДНБ өсөлт буурч байна</b>	2014 онд Монголын Хөрөнгийн Бирж арилжааны болон ханшийн мэдээллийг мобайл апплекейшны туслаамжтайгаар олон нийтэд хүргэх боломжтой болсон.	Монголын Хөрөнгийн Бирж нь гишүүн брокер, дилерийн компаниудаа дэмжиж гишүүнчлэлийн жилийн хураамж, арилжааны системд нэвтрэх эрх буюу терминал ашиглах төлбөрөө бууруулсан.	2014 онд засгийн газрын 389 тоот тогтоолоор 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монгол улсын хөрөнгийн биржээр дамжуулан зах зээлд нийлүүлсэн.
<b>2014 оны эцсийн байдлаар нийт 375.5 мянга ширхэг үнэт цаасыг 36.1 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 60.4 тэрбум</b>		Монголын Хөрөнгийн Биржийн Бүртгэлийн журам шинэчлэгдсэн. Энэхүү журамд Монголын Хөрөнгийн Биржид үнэт цаас	Оюу Толгойн далд уурхайт 2015 онд ашиглалтанц оруулахаар хэлэлцэж байна.

**төгрөгийн гүйлгээ  
хийсн байна.**

гаргах, монголд  
бүртгэлтэй компани  
гадаад улсад үзүүлэлт  
гаргах буюу давхар № 1  
бүртгэл, компанийн  
засаглалын зарчмыг  
дагаж мөрдөх талаар  
нэмж оруулж өгсөн.

**БҮРТГЭВ**

**2014 онд гадаад  
худалдааны нийт бараа  
эргэлт 11.0 тэрбум ам.  
долларт хүрсэн. Үүнээс  
5.8 тэрбум ам доллар нь  
экспорт байгаа бол  
үлдсэн 5.2 тэрбум ам  
доллар нь импорт  
байна.**

Монгол Улсын  
Засгийн газрын үнэт  
цаасны арилжааг  
Монгол Банкаар  
дамжуулан  
арилжаалахыг зогсоож  
Монгол Улсын  
Хөрөнгийн Биржээр  
дамжуулан  
худалдаалж байна.  
2014 оны сүүлээр  
Таван толгой  
нүүрсний ордын  
хөрөнгө оруулагч  
нар тодорсон.  
Хятадын “Чайна  
Шэнхуа Энержи”,  
Японы “Сумитомо  
корпораци”,  
Монголын “Энержи  
Ресурс” ХХК-ийн  
хамтарсан түншлэл  
таван толгойн  
нүүрсний ордод  
хөрөнгө оруулан,  
хөгжүүлэхээр  
болсон.

**Монгол улсад орох  
гадаадын шууд хөрөнгө  
оруулалт өмнөх оны  
мөн үеэс 74% буюу  
1556.3 сая ам доллараар  
буурсан.**

Монгол Улсын  
Засгийн газраас  
Монгол Улсын  
Хөрөнгийн Бирж  
ТӨХК-ийн хувьцаа  
эзэмшигчийн эрх  
үүргийг Сангийн Яамд  
шилжүүлсэн.

**Сүүлийн жилүүдэд  
инфляцийн түвшин  
хэлбэлзэл ондортай  
байгаа.**

**Хөрөнгийн зах зээлийн  
үнэлгээ 13.64% буурч, 1  
их наяд 442.6 тэрбум  
төгрөгт хүрсэн байна.**

**Зураг 9 Микро орчин**

Харилцагч	Нийлүүлэгч	Өрсөлдөгч	Шинэ оролцогч	Орлох бүтээгдэхүүн
<b>Хөрөнгийн Биржээр дамжуулан засгийн газрын бондыг борлуулж байгаа нь харилцагчдын тоог нэмэгдүүлж байна.</b>	2012 оноос хойш гадаадын хөрөнгө оруулагчдын тоо эрс багассан.	2014 оны 12 сарын байдлаар нийт 58 брокерийн компани уйл ажиллагаа явуулж байна. Үүнээс дилерийн 56 компани,	Монголын Хөрөнгийн Биржийн Бүртгэлийн Журам шинчлэгдсэн- ээр шинээр брокер,	Монгол банкаас 2014 онд бодлогын хүүгээ өсгөв.



	андеррайтер 22, хөрөнгө оруулалтын зөвлөхийн давхар эрхтэй 14 компани Үйл ажиллагаа явуулж байна.	дилерийн компаниуд байгуулагдаж байна.
<b>Монголын зах зээл дээрх брокер, дилер, андеррайтрын компаниудын тоо өссөөр байгаа ба нөгөө талаас харилцагчдын орлогын эх үүсвэр нэмэгдэж байгаа нь тэдний зах зээл дэх хүчийг улам бур нэмэгдүүлж байна.</b>	Өрсөлдөгч нар зах зээл дээрх өрсөлдөх чадвараа сайжруулах зорилгоор харилцагч нарынхаа тоог нэмэгдүүлэхээр идэвхитэй ажиллаж байна.	Зах зээлийн сегментчлэл нарийн биш, бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, брокер, дилерийн компани байгуулахад шаардлагатай дүрмийн санг хөнгөлж өгсөн тул шинэ оролцогчид энэ зах зээл дээр гараах боломж өндөр.
	Өрсөлдөгч нар том харилцагч татах зорилгоор үйлчилгээний иж бүрэн байдал, онлайн системийг нэвтрүүлэхэд чиглэн ажиллаж байна	Засгийн газраас унэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байгаа нь шинэ оролцогчдод таатай нөхцөлийг бүрдүүлж байна.
<b>Монголын үйл ажиллагаагаараа тэргүүлэгч томоохон компаниуд анхдагч зах зээлээс хөрөнгө босгох сонирхолтой байгаа</b>		

Макро болон микро орчны нөхцөл байдлаас харахад 2014 онд үнэт цаасны арилжаа буурсан байна. Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын тоо буурах хандлагатай байна. Гэвч шинээр энэ зах зээлд нэвтрэх таатай нөхцөл үүсэж төрөөс хөнгөлөлт үзүүлж байгаа нь харилцагчдын тоо нэмэгдэхэд





нөлөөлж байна. Үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулах хуулийн зохицуулалт шинэчлэгдэж, шинэ бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлж байгаа нь зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлж байна.



Зах зээлийн өсөн нэмэгдэж буй боломжийг ашиглахын тулд компани маркетингийн үйл ажиллагаагаа идэвхижүүлж, өрсөлдөөний давуу тал бий болгон ажиллах шаардлагыг бий болгож байна. Энэ нь цаашид хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний эрэлт өсөх хандлагыг харуулж байна.



### 2.9.3 КОМПАНИЙН ЕРӨНХИЙ СТРАТЕГИ

Бизнесийн гадаад болон дотоод орчны хүчин зүйлс, зах зээлийн боломжуудад тулгуурлан бид өсөлтийн стратеги баримтлан ажиллах хэрэгтэй гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Одоогийн байгаа зах зээлд одоо үзүүлж байгаа үйлчилгээг чанартай түүүлэх, шинэ бүтээгдэхүүн санал болгох замаар зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх хувваарилалтын сувгийн хувьд тэлэх стратеги баримтлан ажиллах замаар бизнесийн өсөлтийг ханган ажиллахад чиглэнэ.

*Зураг 10 Компанийн стратеги*



Бүтээгдэхүүн хөгжүүлэх стратегийн хүрээнд доорх бүтээгдэхүүнийг хөгжүүлэн харилцагчдад санал болгох замаар санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэхийг зорин ажиллана. Үүнд:

- Бизнес, санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
- Нийлэх, нэгдэх хэлцэлд зуучлагчаар оролцох
- Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ
- Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ
- Синдикат үйлчилгээ
- Эрсдэлийн менежментийн цогц үйлчилгээ
- Дотоод хяналтыг хийж гүйцэтгэх
- Хөрөнгийн удирдлагын үйлчилгээ

#### Бизнесийн стратеги

Зах зээлийн боломж, өсөлт болон үндсэн үйл ажиллагаанаас олох орлогын прогноз дээр тулгуурлан бизнесийн стратегийг дараах байдлаар тодорхойлж байна.





Ирээдүйд өсөлт хамгийн өндөр байх, орлого олох боломжтой үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын зөвлөх болон андеррайтерын үйл ажиллагаа гэж үзэж байгаа учраас эдгээр үйлчилгээг хөгжүүлэхэд нөөц боломжкоо түлхүү ашиглан ажиллана.

Зэрэглэвэл:


- Хөрөнгө оруулалтын зөвлөх
- Андеррайтер
- Брокер, дилерийн үйл ажиллагаа

Үйл ажиллагааны стратеги дундаа маркетингийн стратегийг дараах байдлаар нарийвчлан тодорхойлов.

### Маркетингийн стратеги

Компанийн ерөнхий стратеги, зорилго зорилт, бизнесийн стратеги дээр тулгуурлан ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зах зээл дээр эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн маркетингийн бодлого баримтална.

**Зураг 12 Маркетингийн стратеги**

Зорилтот зах зээл	 <p>1. Компани-Санхүүгийн иж бүрэн үйлчилгээг эрхэмлэгч, хамгийн их орлого олох боломжтой зорилтот зах зээл</p> <p>2. Хувь хүн</p>
Бүтээгдхүүний стратеги	Хөрөнгө оруулалтын зөвлөх, менежмент, санхүүгийн зөвлөх, хадгаламжийн бичиг, олон улсын хөрөнгийн бирж дээрээс дотоодын иргэдэд үнэт цаас арилжаалахад зуучлах гэх мэтчилэн санхүүгийн бүтээгдхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн иж бүрэн үйлчилгээг хөгжүүлэхдэд чиглэн ажиллана
Үнийн стратеги	Зах зээл дээр тулгуурласан үнийн стратеги
Хуваарилалтын сувгийн стратеги	Хуваарилалтын сувгийг тэлэх стратеги баримтална
Идэвхижүүлэлтийн стратеги	Push болон Pull стратегийг хэрэгжүүлнэ

**Маркетингийн төлөвлөгөө**
**Үйлчилгээ**

Компани дотоодын болон гадаадын байгууллага болон хувь хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын банкны бүх төрлийн үйлчилгээг үзүүлэхийг зорин ажиллаж байна. Бид энэхүү зорилгodoо хүрэхийн тулд үйл ажиллагаагаа З шатаар төлөвлөж ажиллаж байна. Компани 2008 онд брокер, дилериийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авч ажиллаж байсан бөгөөд төлөвлөгөөний дагуу 2009 онд андеррайтерийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан.


Одоогоор бид дараах үйл ажиллагаануудыг явуулж байна. Үүнд:

- Брокерийн үйл ажиллагаа
- Дилериин үйл ажиллагаа
- Андеррайтерийн үйл ажиллагаа

\* Ирээдүйн гурван жилийн хугацаанд бид бизнесийн болон санхүүгийн зөвлөгөө өгч, нийлэх нэгдэх (M&A) үйл ажиллагаануудад зуучлагчаар оролцож хөрөнгө оруулалтын

банкны иж бүрэн үйлчилгээг үзүүлнэ. Мөн эдгээрээс гадна хувийн хөрөнгө оруулалтын үйлчилгээг үзүүлнэ.

- Бизнес, санхүүгийн зөвлөгөө
- Нийлэх нэгдэх, худалдан авах хэлцэлд зуучлагчаар оролцох
- Хувийн хөрөнгө оруулалт
- Хадгаламжийн бичиг



Бидний эдгээр бүх үйлчилгээ эдийн засаг, салбар, компаниудын нарийвчилсан судалгаан дээр үндэслэж явагдах учраас судалгааны үл ажиллагаа бүх шатанд маш чухал бүрэлдэхүүн хэсэг байх болно. Бид байгуулагдсан цагаасаа хойш Монгол улсын эдийн засаг, голлох салбарууд болон компаниудын судалгааг бэлтгэж олон нийтэд нээлттэйгээр танилцуулж байгаа бөгөөд энэхүү үл ажиллагаа компанийн болоод хөрөнгийн зах зээлийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа гэж бид үзэж байгаа юм.

#### **Зах зээл, түүнд эзлэх компанийн үл ажиллагааны төлөвлөгөө**

Бид дараагийн жилүүдэд үндсэн үйлчилгээнээс олох орлогын төлөвлөгөө гаргахын тулд ДНБ-ний төсөөлөл дээр суурилан, хөрөнгийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцоолоод байна.

*Xүснэгт 17 Зах зээлийн таамаглал, тэрбум төгрөгөөр*

	2014	2015E	2016E	2017E	2018E
<b>ДНБ</b>	21,844	24,902	28,388	32,363	36,894
<b>Арилжааны хэмжээ</b>	60	69	80	92	106
<b>Зах зээлийн үнэлгээ</b>	1,442	1,543	1,651	1,767	1,890
<b>Зах зээлийн үнэлгээ/ДНБ харьцаа</b>	6.60%	6.20%	5.82%	5.46%	5.12%
<b>Зах зээлийн эргэлт/Үнэлгээ харьцаа</b>	4%	5%	5%	5%	6%

Компани нь 2011 онд арилжааны дүнгээрээ зах зээлд 2-рт орж байсан бол 2014 онд нийт хувьцааны арилжааны 1.20%-ийг хийсэн. 2016 онд манай компани нийт 2.4 тэрбум төгрөгийн арилжаа хийх зорилготой байгаа бөгөөд бидний тооцоогоор энэ нь нийт зах зээлийн арилжааны 3% байхаар байна.

*Xүснэгт 18 Зах зээлийн таамаглал, тэрбум төгрөгөөр*

	2016E	2017E	2018E	2019E	2020E
<b>Брокер</b>	3%	4%	5%	6%	7%
<b>Арилжааны хэмжээ</b>	80	92	106	121	140
<b>Брокерийн арилжаа</b>	2.4	3.68	5.3	7.26	9.8

Дараагийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор Монголын хадгаламжийн сертификатын арилжааг нэвтрүүлэх, дотоодын томоохон компаниудын хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, Монголд үл ажиллагаа явуулдаг олон улсын компаниудын хувьцааг Монголын хөрөнгийн зах зээлд давхар бүртгүүлэх ажлуудыг амжилттай хийхийн тулд компаниуд, хөрөнгийн биржүүдтэй нягт хамтран ажиллана.

“Евразия Капитал Холдинг УЦК” ХК нь хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх эрх 2011 онд авсан. Банкны зээлийн хүү асар хурдтай өсч, хувьцааны санхүүжилт өсч буй энэ үед Монголын компаниудын хувьд үйл ажиллагаагаа амжилттайгаар үргэцжээдүүлэн явуулахын тулд зөвхөн банкны зээлд найдаж суух биш цаашид гадаадын шууд хөрөнгө оруулалтанд анхаарах шаардлага үүсч байна. Энэ шаардлагын дагуу засгийн газраас хуудын эрх зүйн биччийн хувьд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах таатай нөхцөл бололцоог бүрдүүлж өгсөн. Сүүлийн 2 жилд гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан ч ирээдүйд урьд жилүүдээс илүүгээр өсөх магадлалтай. Энэхүү гадаадын шууд хөрөнгө оруулалтыг амжилттай олж гадаадын хөрөнгө оруулагчидтай холбоо тогтоож, амжилттай хэлэлцээр хийхэд Монголын компаниуд зөвлөгөө авах шаардлага байгаа бөгөөд энэхүү зөвлөхийн үйлчилгээг “Евразия Капитал Холдинг УЦК” ХК хүргэхээр ажиллаж байна.

Энэ зах зээлд тавьж буй зорилгоо хэрэгжүүлэхийн тулд манай компани дараах стратегийг баримтлан ажиллахаар төлөвлөөд байна. Үүнд:

- Стандартад нийцсэн хөрөнгө оруулалтын илтгэл бичих, компанийн нарийвчилсан судалгаа (due diligence) хийх болон бизнес төлөвлөгөө бичихэд нь Монголын компаниудад зөвлөгөө өгөх
- Компанийн зүгээс тодорхойлж буй бизнесийн стратегийн төлөвлөгөө болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр суурилан хөрөнгө оруулагчдын сонирхолд нийцэхүйц өсөлтийн стратегийг зөвлөх
- Хямдруулсан мөнгөн урсгалын шинжилгээ, харьцуулсан шинжилгээ зэрэг олон улсад өргөн хэрэглэгддэг стандарт аргуудаар компанийн үнэлгээ хийх
- Хөрөнгө босгож аль оновчтой хувилбарыг зөвлөх (бонд гаргах, зээл авах, хувьцаа эсвэл төрөл бүрийн хөрвөх үнэт цаас гаргах гэх мэт)
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах
- Хөрөнгө оруулагчдын чанарыг үнэлж, хөрөнгө оруулалтын нөхцлийн талаар хөрөнгө оруулагчид болон компаниудтай хэлэлцэх.
- Хадгаламжийн сертификатын үйлчилгээг (depository receipts) нэвтрүүлж, зөвлөгөө өгөх. Ингэснээр гадаад зах зээл дээр хадгаламжийн сертификатыг гаргах шаардлагыг хангаж буй дотоодын хувьцаат компаниуд гадаад хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалах боломжтой болж байгаа юм.
- Монгол болон гадаад улсад бүртгэлтэй хувьцаат компанийг Монгол, гадаад улсын хөрөнгийн биржид зуучлан давхар бүртгүүлэхэд (dual-listing) зөвлөгөө өгөх замаар гадаад дотоодын харилцагчдыг татах
- Компанийг нэгтгэх, хуваах, өөрчлөх (mergers and acquisitions) үйлчилгээ нэвтрүүлэх

Бид хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх үйлчилгээгээ хоёр талын гэрээн дээр үндэслэн явуулах бөгөөд 2016-2020 оны хооронд жилд арваас доошгүй компанийд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үзүүлнэ хэмээн төлөвлөгөө боловсруулаад байна. Компанитай гэрээ байгуулсаны дараа авах урьдчилгаа төлбөрийн хэмжээ 2016 онд 20 сая төгрөг ба түүнээс багагүй байх бол 2020 онд 100 сая төгрөг болно гэж таамаглалаа. Хөрөнгө



оруулалтын зөвлөхийн үйлчилгээнээс олох үндсэн орлого нь компанийд санхүүжилт амжилттай олж өгсөн тохиолдолд авах 5%-ийн шимтгэлийн орлого байхаар харагдаж байна.

**БҮРГГЭВ**  
№ 01

*Хүснэгт 19 Хөрөнгө оруулалт болон дилерийн үйл ажиллагаа, сая тогrog*

	2016E	2017E	2018E	2019E	2020E
Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний орлого	30	50	70	90	120
Дилерийн үйл ажиллагааны орлого	100	110	121	133	146

**Үйлчлүүлэгч, харилцагчид**

Компани нь гадаадын зах зээлд чиглэх үйл ажиллагаанд гадаадын худалдан авах тал (buy-side)-ын байгууллагын хөрөнгө оруулагчид, түүний дотор сангийн менежментийн харилцагчдыг татах бодлогыг баримтална. Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлд байгууллагын хөрөнгө оруулагчдыг түлхүү татаж, багцын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бөгөөд салбарын хөгжилд хувь нэмэр оруулах болно.

*Хүснэгт 20 Брокерийн үйлчилгээний зорилтот үйлчлүүлэгчид*

Гадаад	Дотоод
<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагын хөрөнгө оруулагчид</li> <li>• Хөрөнгө оруулалтын сангийн менежментийн харилцагчдыг татах бодлогыг баримтална</li> <li>• Багцын сан /Equity fund/</li> <li>• Хөгжлийн сангийн менежментийн харилцагчдыг татах бодлогыг баримтална</li> <li>• Хувь хүн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хувь хүн</li> <li>• Компаниуд</li> </ul>

## 2.9.4 АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Андеррайтерийн үйлчилгээний хувьд бид дараах салбарын компаниудын хувьцааг хөрөнгийн биржид зуучлан борлуулахад түлхүү анхааран ажиллах болно. Үүнд:

- Уул уурхай
- Барилгын материал
- Дэд бүтэц
- Аялал жуулчлал
- Интернет, Шуудан Холбоо



Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний хувьд мөн дээрх салбараудын компаниудад голлон үйлчилгээ үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

Үүнээс гадна “Евразия Капитал Холдинг ҮЦК” ХК нь 2015-2016 онд зарлаж буй төрийн өмчit компаниудын хувьчлалын тендert оролцох болно. Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолын хавсралтаар дараах ТӨХК-иуд хувьчлагдан, өөрчлөн байгуулагдана.

**Xүснэгт 21 Хувьчлах, өөрчлөн байгууллагдах ТӨХК**

д/д	Хуулийн этгээдийн нэр	Байршил	Хувьчлах хувь, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа (улирал)	Хувьчлах бэлтгэл ажлын хүрээнд авах арга хэмжээ, хувьчлах арга, хэлбэр, нохцэл
1.	“Дулааны цахилгаан станц-4” ТӨХК	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн техник, технологийг шинэчлэхэд ашиглах
2.	“Дулааны цахилгаан станц-3” ТӨХК	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн техник, технологийг шинэчлэхэд ашиглах
3.	“Дулааны цахилгаан станц-2” ТӨХК	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах
4.	“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК	Дархан-Уул аймаг Дархан сум	Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин

					чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах
5.	“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК	Орхон аймаг Баян-Өндөр сум	Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшигт 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах
6.	“Шивээ-Овоо” ХК	Говьсүмбэр аймаг Шивээговь сум	Нийт хувьцааны 51 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд бэлтгэл хангаж, 2016 онд хэрэгжүүлэх	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлүүлэх: -нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох; -нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгох эсэхийг шийдвэрлэх. Эдгээр арга хэмжээг авсны ундсэн дээр компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар компанийн нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх
7.	“Багануур” ХК	Улаанбаатар Багануур дүүрэг	Нийт хувьцааны 51 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд бэлтгэл хангаж, 2016 онд хэрэгжүүлэх	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлүүлэх: -нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох; -нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгох эсэхийг шийдвэрлэх. Эдгээр арга хэмжээг авсны ундсэн дээр компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар компанийн нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх
8.	“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	Цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааг	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс салгаж, бие даасан хуулийн этгээд болгон хувьчлах

Хувьчлах					
9. "Оргил рашаан сувилал" ТӨХК	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	100 хувь хувьчлах	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанид сувиллын лавлагаа, судалгааны үйл ажиллагааг нэмж хариуцуулан зохион байгуулж, үндээн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүй байх <b>нохцөлтэйгөөр нээлттэй</b> дуудлагын худалдаагаар худалдах	
10. "Кино урлагийн дээд сургууль" ХХК	Улаанбаатар Баянзүрх дүүрэг	Төрийн эзэмшилийн хувьцааг (51 хувь) хувьчлах	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгож, татгалзсан тохиолдолд нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах	
11. "Хөдөө аж ахуйн бирж" ХХК	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг	Нийт хувьцааны 34 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд бэлтгэл хангаж, 2016 онд хэрэгжүүлэх	Компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 34 хувь байх хэмжээнд, түүний технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгийн санхүүжилтэд хамтарч ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагч этгээдэд оруулсан хөрөнгөд нь тохируулан нэмэлт хувьцаа гарган эзэмшүүлэн хувьчлах	
12. "Авто импекс" ХК	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг	Төрийн эзэмшилийн хувьцааг (51 хувь) хувьчлах	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн төрийн эзэмшлийн хувьцааны доод үнэ дээр Сангийн яаманд төлөх төлбөрийг нэмж нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах	
13. "Монгол шуудан" ТӨХК	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг	Нийт хувьцааны 66 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн нийт хувьцааны 34 хувьтай тэнцхээд хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, орлогыг компанийн үйл ажиллагааг сайжруулах эх үүсвэр болгон ашиглах	
14. "Монголын цахилгаан холбоо" ХК	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг	Төрийн эзэмшилийн хувьцааг (54.67 хувь) хувьчлах	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Төрийн эзэмшилийн хувьцаа БНСҮ-ын "Корей Телеком" компанид худалдан авахыг санал болгож, татгалзсан тохиолдолд хөрөнгийн зах зээлд нийтэд худалдах	
15. "Хөтөлийн цемент шохой" ТӨХК	Сэлэнгэ аймаг Сайхан сум	100 хувь хувьчлах	2015 оны IY улиралд хэрэгжүүлэх	Компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нохцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах	

## 2.9.5 ХАДГАЛАМЖИЙН БИЧИГ

“Евразия Капитал Холдинг УЦК” ХК нь үнэт цаасны тухай хуулиар зөвшөөрөгдсөн хадгаламжийн бичгийн үйлчилгээг Монгол Улсад анх удаа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаад байна. Компанийн гүйцэтгэх удирдлагууд Монголын хөрөнгийн зах зээл дээр шинэ бараа бүтээгдэхүүн болон хадгаламжийн бичгийг төлөвлөгөөний дагуу гаргахаар дэлхийн тэргүүлэгч хөрөнгө оруулалтын банк болох BNY Mellon банкны төлөөлөгч партай уулзаж хамтран ажиллах талаар зөвшилцсөн.

Монгол Улсын Үнэт цаасны тухай хуулийн 4.1.12 дугаар зүйлд зааснаар хадгаламжийн бичиг гаргагч /депозитор/ сурь үнэт цаасыг үнэт цаасны хадгаламж /кастодиан/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хадгалуулсны үндсэн дээр өөр улсын үнэт цаасны зах зээлд арилжих зорилгоор гаргасан үнэт цаас гэж тодорхойлж байгаа.

Хадгаламжийн бичиг олон төрлийх байдаг бөгөөд үүнээс 3 томоохон хэлбэрүүд нь Америкийн биржүүд дээр гаргасан Америкийн ХБ (ADR), зөвхөн Европын хөрөнгийн биржүүд дээр гаргасан Европын ХБ (EDR), Америк болон бусад улсуудын биржүүд (голчлон Европын, тухайлбал Лондон, Люксембург, г.м)-ийн аль аль дээр гаргасан Глобал ХБ (GDR) юм.

Хадгаламж бичиг нь дараах ашиг тус үзүүлнэ:

### Компанид үзүүлэх ашиг тус:

- Дотоодын хөрөнгө оруулагчдын тоо цөөн, ихээхэн хэмжээний хөрөнгө босгоход төвөгтэй байдаг бол ХБ гаргаснаар хөрөнгө оруулагчдын тоог нэмэгдүүлэн, гадаад хөрөнгө оруулагчидтай болдог. Мөн томоохон хэмжээний санхүүжилт татах боломжтой болдог.
- Олон улсын хөрөнгө оруулагч, хэрэглэгч, үйлчлүүлэгчид компанийг мэддэг болдог. Нэгэн төрлийн сурталчилгаа болж өгнө.
- Компанийн хувьцааны хөрвөх чадвар сайжирна.
- Олон улсын шинжээчид компанийн судалгааг хийж эхэлнэ. Компанийн хувьцаа ижил төрлийн гадаадын компаниудтай ижил үнэлэгдэнэ.
- Цаашид шинээр хувьцаа гаргаж, хөрөнгө татахад таатай нөхцөл бүрдэнэ.

**АХБ-ын үед:** Олон улсын хэмжээнд компанийг худалдах-худалдан авах хэлцэл хийхэд ХБ-ийг ашиглан хийх боломжтой болдог.

### Хөрөнгө оруулагчдад үзүүлэх ашиг тус:


- Худалдаж авах, зарахад хялбар.
- Хөрөнгө оруулагч өөрийн орны компанийн хувьцааг худалдаж авч буйтай яг ижил зарчмаар авдаг.
- Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын багцаа төрөлжүүлэх /diversification/ боломжийг олгодог.
- ХБ хөрөнгө оруулагчдад учрах зардал, бэрхшээл болох валют, төлбөр тооцоо, хэл



болон хэт олон зуучлагчдын асуудлыг бууруулдаг.

- Хамтын сан, тэтгэвэрийн сан гэх мэт гадаадын хувьцаануудад хөрөнгө оруулахыг хориглосон байгууллагын хөрөнгө оруулагчидад гадаадын хувьцаанд хөрөнгө оруулах боломж олгодог.
- Биржид бүртгүүлсэн ХБ нь хуулиар шаардсан үйл ажиллагааны болон санхүүтийн мэдээллээ нийтэд ил болгодог.

ХБ-ууд нь тухайн улсын хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлдэг.




### МХБ-д үзүүлэх ашиг тус:

- Тухайн улсын хувьцаануудын эрэлтийг нэмэгдүүлнэ
- Тухайн улсын хөрөнгийн биржууд дээрх арилжаа, хөрвөх чадварыг нэмэгдүүлнэ
- Тухайн улсын хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээний хэмжээг нэмэгдүүлнэ
- Тухайн улсын хөрөнгийн биржийн нэр хүндийг олон улсын түвшинд өсгөнө
- Тухайн улсын хөрөнгийн биржийг тухайн улсын компаниудынх нь нүдэнд илүү анхаарал татам болгоно
- Тухайн улсын компаниудын шинээр IPO хийх болон нэмж хувьцаа гаргах сонирхол өснө
- Жишээ: Казакстанын Хөрөнгийн биржийн зах зээлийн нийт үнэлгээ 2005 онд ~5 тэрбум ам.доллар байсан бол олон улсын биржууд дээр шууд хувьцаагаар болон ХБ-ээр дамжуулан IPO хийснээр зах зээлийн үнэлгээ нь 3 жилийн дотор ~100 тэрбум ам.доллар болж өссөн.


### ХАДГАЛАМЖИЙН БИЧИГ, ЖИЛЭЭР

Спонсортой Хадгаламжийн Бичиг



2013 онд 85 спонсортой Хадгаламжийн бичиг бүртгэгдсэн бол,  
2014 онд шинээр 77 ХБ бүртгэгджээ

Нийт Спонсортой болон Спонсогүй Хадгаламжийн Бичиг



Дэлхий даяар нийт 75 орны 3742 ХБ-ийн програм  
бүртгэлтэй байна.

## ХАДГАЛАМЖИЙН БИЧИГ, САЛБАРААР

2014 оны TOP 10 салбар, мөнгөн дүнгээр (ТЭРБУМ)


САЛБАР	2014 он	Форчилт 2013 оноос
Интернет програм хангач	\$619.8	187.70% ↑
Газрын төс, байгалийн хий	\$497.4	16.67% ↑
Эм зүй	\$322.9	73.37% ↑
Металл уулзуртай	\$209.8	-0.81% ↓
Банк, санхүү	\$207.0	9.00% ↑
Хагас данкуулач тоног тээвэрэмж	\$171.6	-2.76% ↓
Утасгүй холбоны үйлчилтээ	\$155.1	-16.73% ↓
Интернет худалдаа	\$127.8	265.83% ↑
Ус уудаз	\$88.9	42.23% ↑
Харилцаа холбоны тоног тээвэрэмж	\$68.8	-20.61% ↓

2014 оны TOP 10 салбар, хувьцасны тоогоор (ТЭРБУМ)

СЭХ ОН... СОР... БДР <b>БҮРТГЭВ</b> 2014 он № 01 Форчилт 2013 оноос		
САЛБАР	Банк	ЗЭХ
Газрын төс, байгалийн хий	275	18.77% ↑
Митал, уулзуртай	197	9.97% ↑
Хагас данкуулач тоног тээвэрэмж	112	-34.50% ↓
Интернет, програм хангач	104	140.62% ↑
Харилцаа холбоны тоног тээвэрэмж	78	-49.84% ↓
Утасгүй холбоны үйлчилтээ	62	-13.84% ↓
Интернет худалдаа	58	286.71% ↑
Эм зүй	51	42.30% ↑
Ус уудаз	40	195.10% ↑

## СПОНСОРТОЙ БА СПОНСОРГҮЙ ЗАХ ЗЭЭЛ

### ХБ-ИЙН БУРЭН СПОНСОРТОЙ ХӨТӨЛБӨРҮҮД



### ХБ-ИЙН БҮХ СПОНСОРГҮЙ ХӨТӨЛБӨРҮҮД, ТОЛ 5 СЕКТОР



77

2014 онд 77 спонсортой  
ХБ шинээр бүртгэгдсэн

2,142

Енэведэр 2,142 спонсортой ХБ байна

60%

BNY Mellon бүх спонсортой  
ХБ-ийн зах зээлийн 60%-ийг  
зээлдэгт

65%

2014 онд 89 биржийн бус,  
спонсортой ХБ шинээр  
бүртгэгдсэн багаад BNY Mellon  
65%-ийг нь дэнгвэрээ  
хариуцаж гаргасан


41%

Нийт 1,600 идэвхийтэй  
спонсортой ХБ байгаагаас  
BNY Mellon дэнгвэрээ 41%-  
ийг нь хариуцаж гаргасан


ХОЛДЫН СҮРХ

EURASIA CAPITAL  
HOLDING JSC

79 | Page



БАЙГУУЛЛАГЫН ХАДГАЛАМЖИЙН БИЧГИЙН ӨМЧЛӨЛ



АЗИ НОМХОН ДАЛАЙ


АРИЛЖИГДСАН УНИЙН ДУН  
(ТЭРБУМ)




ТОП 5 ХБ. АРИЛЖИГДСАН  
УНИЙН ДУНГЭЗЭР (ТЭРБУМ)



АРИЛЖИГДСАН ТОО  
ШИРХЭГ (ТЭРБУМ)



ТОП 5 ХБ. АРИЛЖИГДСАН  
УНИЙН ДУНГЭЗЭР (ТЭРБУМ)



Хүчин арилжигдсан унийн  
дунгээрх топ секторууд  
(тэрбум)

Х: ХБ-ийн тоо ширгээ / тарбинаар/  
Р: ХБ-ийн хотын борууд.

**\$608.8**

Интернет Програм  
хангамж  
V.10.8P.  
27



**\$137.3**

Интернет  
худалдаа  
V.6.8P.12



**\$125.7**

Хагас  
боловсруулсан  
бүтээгдхүүн



**\$53.2**

Металл болон  
уулзурхай



**\$44.2**

Zochid Buudal, Restoran  
болов Амдралтыг газар



XORIGIIN TUR


EURASIA CAPITAL  
HOLDING JSC

ЕВРОП, ОЙРХИ ДОРНОД БОЛОН АФРИК

ҮННИЙ ДҮН (ТЭРБУМ)




АРИЛЖИГДСАН ТОО ШИРХЭГ (ТЭРБУМ)




Топ 5 ХБ-арилжигдсан үнний дүнээр (тэрбум) Тогшижин

Топ 5 ХБ-ийн зах зээлийн үзлэгээгээр (тэрбум)




Латин Америк

Арилжигдсан үнний дун (тэрбумаар)




Арилжигдсан тоо ширхэгээр (тэрбумаар)




Арилжигдсан үнний дүнээрх топ 5 ХБ-ийн хөтөлбөрүүд (тэрбумаар)

ХБ-ийн арилжигдсан үнний дунээрх топ секторууд (Тэрбумаар)



## ХБ, ЗАХ ЗЭЭЛИЙН МАНЛАЙЛАЛ

BNY Mellon бол дэлхийн хамгийн том хадгаламжийн бичгийн компани бөгөөд зах зээлийн дийлэнх хувийг ззэлдэг. BNY Mellon хил дамнасан хөрөнгө оруулалтыг илүү хялбарчлах тал дээр анхаарч ажилладаг бөгөөд хил хязгааргүй хөрөнгө оруулалтыг дэмжин, иж бурун хадгаламжийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг.



спонсортой хб-ийн зах зээлд эзлэх хувь

Бүх ХБ

60% 13% 15% 12%

Ази, Номон дайв

54% 21% 14% 11%

Европ, Сіярх, Дорнод, Африк


61% 7% 20% 12%

Латин Америк

70% 8% 13% 16%

BNY Mellon Citibank Deutsche Bank JPMorgan

### 15 ЖИЛИЙН АМОЖЛПТЫН ТҮҮХ



### ТОР 10 ХАДГАЛАМЖИЙН БИЧИГ (ТЭРБУМ)

КОМПАНИ	АРИЛЖИГДСАН ТОО	ХБ
Petrobras	10.97	BNY Mellon
Vale	7.92	JPMorgan
Gazprom	7.33	BNY Mellon
Sberbank	5.30	BNY Mellon
Nokia	4.69	Citibank
VTB Bank	4.23	BNY Mellon
Ambev	3.21	BNY Mellon
Itau Unibanco	3.11	BNY Mellon
Союзнефтегаз	2.91	Citibank
Vipshop	2.80	Deutsche Bank



EURASIA CAPITAL  
HOLDING JSC

**ХАДГАЛАМЖИЙН БИЧИГ, ХӨРВӨХ ЧАДVAR:**
**Top 5 АМЕРИКТ-БҮРТГЭЛТЭЙ ХБ, МӨНГӨН ДҮНГЭЭР  
ХБ ГАРГАГЧ САЛБАР**
**УЛС**


Alibaba	Интернет, програм хангамж	Хятад	NYSE
Baidu	Интернет, програм хангамж	Хятад	NASDAQ
Petrobras	Газрын тос, байгалийн хий	Бразил	NYSE
Vale	Метал, уул уурхай	Бразил	NYSE
BP	Газрын тос, байгалийн хий	Их Британи	NYSE

**Top 5 АМЕРИКИЙН БИРЖИЙН БУС ХБ, МӨНГӨН ДҮНГЭЭР  
ХБ ГАРГАГЧ САЛБАР**
**УЛС**
**БИРЖ**

Roche	Эм зүй	Швейцарь	Биржийн бус (OTCQX)
Siemens	Эм зүй	Герман	Биржийн бус
Nestle	Хүнсний бүтээгдэхүүн	Швейцарь	Биржийн бус
Tokyo Electron	Хагас дамжуулагч тоног төхөөрөмж	Япон	Биржийн бус
Softbank	Утасгүй холбооны үйлчилгээ	Япон	Биржийн бус

**Top 5 ЛХБ-ЭЭР АРИЛЖИГДСАН ХБ, МӨНГӨН ДҮНГЭЭР  
ХБ ГАРГАГЧ САЛБАР**
**УЛС**
**БИРЖ**

Gazprom	Газрын тос, байгалийн хий	Орос	ЛХБ
Sberbank	Арилжааны банк	Орос	ЛХБ
Lukoil	Газрын тос, байгалийн хий	Орос	ЛХБ
Norilsk Nickel	Метал, уул уурхай	Орос	ЛХБ
Rosneft	Газрын тос, байгалийн хий	Орос	ЛХБ



Лондонгийн хөрөнгийн бирж дээр хадгаламжийн бичгийг бүртгэх шалгууруудын жишээ:

- (1) Зохих хууль ёсны дагуу байгуулагдсан байх
- (2) Байгуулагдсан газрынхаа хууль дүрэмд (42, 52 заалтыг харах) таармуулан үйл ажиллагаа явуулах

LR18.2.4R Үнэт цаасыг төлөөлж буй гэрчилгээ нь заавал:

- (1) Хэвлэгч улсын хууль журмын дагуу байх
- (2) Үнэт цаасыг хэвлэгч талын улсын хууль дүрмийн дагуу албан ёсоор зөвшөөрөгдсөн байх,
- (3) Ямар нэгэн шаардлагатай хуулийн заалтыг биелүүлэх (45 болон 53 дахь заалтыг харах)

LR18.2.5R (1) Үнэт цаасыг төлөөлж буй гэрчилгээ нь заавал хөрвөх чадвартай байх (46, 54, 60 заалтыг харах)


(2) Үнэт цаасыг төлөөлж буй гэрчилгээний төлбөр заавал төлөгдсөн байх. Түүнчлэн өөр бусдад шилжүүлэх хориглолтоос чөлөөлөгдсөн байх.

LR18.2.6G Хэрвээ шилжүүлэлт нь хориглогдоогүй болон хөрөнгө оруулагчид нь үнэт цаасыг худалдан борлуулах боломжтой болгох бүхий л мэдээлэл хангаж өгсөн тохиолдолд Санхүүгын Удирдах Байгууллага нь LR18.5R заалтыг өөрчилж болно. (46, 54 заалт) гэх мэт шалгуурууд байна.



## 2.9.6 АЖИЛТНУУДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Бид нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн тодорхой хэсгийг өөрийн компанийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.



Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр нь компани ажилчиддаа өөрийн компанийн хувьцааг эзэмшүүлэх хөтөлбөр бөгөөд ажилчдын зүгээс ямар нэгэн зардал гардаггүй. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хувьцаа нь ажилчдад өгөх урамшууллын нэг хэлбэр юм. Хувьцаа ажилтнуудад тараагдаж, компани ажилчиддаа компанийг удирдах илүү их боломж олгодог.

Гэхдээ ихэнх компаниуд АХЭХ-ийг ажилчдаа урамшуулах, гэнэтийн хувьцааны халдлагаас урьдчилан сэргийлэх болон компаний өөрийн гэсэн соёлыг төлөвшүүлэх зорилгоор хэрэгжүүлдэг. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр нь нэг ажилтанд хэт их хувьцаа эзэмшүүлэхээс сэргийлдэг.

### Түүх

19-р зууны дунд үед Америк аж үйлдвэржсэн эдийн засагт шилжих үед Procter & Gamble, Railway Express, Sears & Roebuck гэх мэт үндэсний компаниудын ажилчид бүх насаараа нэг компанийд 20 гаран жил ажиллаж, хөгшрөөд цаашид хөдөлмөрлөх боломжгүй болох үедээ ямар ч орлогогүй болж байсан. Ийнхүү эдгээр компаний удирдлагууд компанийхаа хувьцаанаас тодорхой хувийг ажилчдаа тэтгэвэрт гарах үед нь олгож байх шийдвэр гаргаснаар Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр үүссэн түүхтэй.

1956 онд Louis Kelso *Peninsula Sonini* ажилчдад компанийхаа үүсгэн байгуулагчдын хувьцааг худалдан авах боломж олгосноор анхны Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг эхлүүлсэн. 1974 онд Сенатын Санхүүгийн Хорооны дарга, Сенатор Russell Long Ажилчны Тэтгэвэрийн Орлогын Хувьцааны Тухай Хуулийг баталснаар Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн татварын бодлогыг хөгжүүлсэн байdag. 2001 онд АНУ-ийн Конгресс Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн үр шимийг компаний ажилчин, хөрөнгө оруулагч нар эрх тэгш хүртэхийг шаардсан Дотоод Орлогын Хуульд 409(p) хэсгийг нэмж оруулсан.

Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрт ажилчдын итгэмжлэлийн санг байгуулж, бэлэн мөнгө оруулж компаний хувьцааг авах эсвэл компаний хувьцааг шууд оруулах замаар санхүүждэг. Нөгөөтэйгүүр компани итгэмжлэлийн сангаа мөнгө зээлэн хувьцаа авч АХЭХ-ийг санхүүжүүлэх сонголт хийж болдог. Хэрвээ итгэмжлэлийн сан мөнгө зээлсэн тохиолдолд, компани нь уг сандаа хөрөнгө оруулж, зээлээ эргэн төлөх боломж олгодог бөгөөд энэ нь татвараас чөлөөлөгддөг. Ерөнхийдөө компанийд дор хаяж 7 хоногт 20 цаг, 1-ээс дээш жил ажилласан, байнгын хөдөлмөрийн гэрээтэй ажилчид Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрт хамрагдах боломжтой байдаг. Гэхдээ зарим компаниуд олон жил ажилласан ажилчиддаа илүү их хувьцаа олгодог бөгөөд үйл ажиллагаа нь тогтвортсон компанийд хүртэл шинэ ажилчид уг хөтөлбөрт оролцох боломж бага байх тохиолдол байдаг.

Мөн Америкт ажилчид компаниасаа гарах эсвэл тэтгэвртээ гарахдаа Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрөөс олголт авах үедээ л татвар төлдөг бөгөөд тэр хүртэл ямар нэгэн татвар төлдөггүй. Мөн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн дансан дахь хөрөнгөө Хувийн Тэтгэврийн Сан руу шилжүүлэх боломжтой байдаг. Вашингтон мужид үйл ажиллагаа явуулдаг бүх ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн компаниудыг хамарсан судалгаанд дурдсанаар ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг компани илүү амжилттай байдаг бөгөөд эдгээр компаний цалин ижил салбарын бусад компаниудтай харьцуулахад 5-12% илүү байдаг байна. Эрдэмтдийн судалгаагаар Америкийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг компаниуд жилдээ дунджаар 14 тэрбум ам.долларыг уг хөтөлбөрт оруулдаг аж. Түүнчлэн өөр нэг судалгаагаар Америкийн нийт ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг компаниудын ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хадгаламж, ажлын байрны тогтвортой байдал, хөдөлмөрийн бүтээмж гэх мэт эдийн засгийн үр ашиг жил бүр 33 тэрбум ам.доллар байдаг гэсэн тоо баримт гарчээ.

2013 оны нэгэн судалгаагаар 2010 онд Америкт 2,643 ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг компаниуд 470,000 ажилтантай бөгөөд нэмэлт 940,000 хүнийг ажлын байраар хангаж, 29 тэрбум ам.долларын цалин хөлсийг ажилчиддаа олгож, 48 тэрбум долларыг нэмэлт ажлын байранд төлсөн бөгөөд орон нутгийн засгийн газруудад төвлөрүүлсэн татварын орлого 11 тэрбум долларт, холбооны засгийн газарт төвлөрүүлсэн татварын орлого 16 тэрбум ам долларт хүрсэн гэсэн тооцоо байна. Түүнчлэн, уг судалгаагаар ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг компаниудын үйлдвэрлэл 2010 оны Америкийн ДНБ-ны 1.7 хувьтай тэнцүү буюу 246 тэрбум ам долларт хүрсэн байна.

2015 оны байдлаар Үндэсний Ажилчдын Хувьцаа эзэмшилтийн Төвийн судалгаагаар 13,5 сая ажилчныг хамарсан 7,000 орчим ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр Америкт байдаг аж. 21-р зууны эхнээс ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн тоо нь буурсан боловч, уг хөтөлбөрт оролцогчдын тоо өссөн үзүүлэлттэй байна. Нийтдээ Америкийн ажилчид компаний хувьцааны 8% орчмыг эзэмшидэг. 2000 оны Rutgers-ийн судалгаа ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг компаниуд энгийн компанийтай харьцуулахад 2.3-2.4% илүү өсөлт үзүүлдэг. Үндэсний Ажилчдын Хувьцаа эзэмшилтийн Төвийн судалгаагаар компаний удирдлагад оролцох боломжийг олгодог ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөртэй компаниуд бусад компанийтай харьцуулахад жилд 8-11% илүү өсөлт үзүүлдэг аж.

Гэхдээ нөгөөтэйгүүр компаний үйл ажиллагаа тааруу байвал ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр нь ажилчны санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлэх сөрөг талтай байдаг. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрөөр ажилчны тэтгэврийн хадгаламжийг бүхэлд нь ганц компаний хувьцаанд хөрөнгө оруулдаг байдал нь хувьцаагаа компани, салбар, газар зүйн байршилаар төрөлжүүлэх гэсэн хөрөнгө оруулалтын онолын эсрэг зүйл юм. Түүнчлэн ажилчин өөрийн ажиллаж хоолоо залгуулдаг, цалин эрүүл мэндийн даатгал гэх мэт хөнгөлүүдийг \* эдэлдэг тэр компанийд нь ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр ажилчны тэтгэврийн хадгаламжийг төвлөрүүлдэг нь хөрөнгө оруулалтын төрөлжүүлэлтийн асуудлыг улам лавтагадаг сөрөг талтай.

Сүүлийн үеийн Үндэсний Ажилчдын Хувьцаа эзэмшилтийн Төвийн судалгаагаар, дундаж ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөйн оролцогч АХЭХ-ийн олголтоор жилд 4,443 ам доллар авдаг бөгөөд дансны үлдэгдэл нь 55,836 ам доллар байдаг байна. Уг хөтөлбөрт олон жил оролцож буй ажилчдын дансны үлдэгдэл бүр их байдаг. Бүх л төрийн хэмжээтэй компаниуд ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Зарим алдартай компаниудыг дурдвал: Publix Super Markets (160,000 ажилчидтай), Lifetouch (25,000), W.L. Gore and Associates (10,000), Davey Tree Expert (7,800). ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөртэй компаниуд Fortune Сэтгүүлийн “Америкийн шилдэг 100 компани” жагсаалтын талаас илүү хувийг жил бүр эзэлдэг.


АХЭХ нь олон давуу талтай бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь компаний ажилчид тогтвортой суурьшилтай, үр бүтээлтэй ажиллахад нөлөөлөх бөгөөд улмаар компаний удирдлагад ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх замаар компанийн засаглалыг сайжруулах, хүнийн нөөцийг чадавхижуулах зэрэг ач холбогдолтой. Компанийн хувьцаа эзэмшигчид болон ажилчид эрх ашгаа нэгтгэн, нэг зорилго руу тэмүүлсэний үндсэн дээр компани амжилтанд хүрдэг. Уг хөтөлбөрийн гол үр дүн бол компаний ажилтнууд ажилдаа илүү хариуцлагатай, өөриймсгөөр ханддаг болох, улмаар ирээдүйд компани тогтвортой, амжилттай үйл ажиллагаа явуулах явдал юм.

Тиймээс бид компанийхаа ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг дараах байдаар хэрэгжүүлэхээр төлөвлөн журмаа боловсруулан Төлөөлөн Удирдах Зөвлөлөөрөө батлуулаад байна.

Тус компанийд ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй байсан хугацааг хасаад цэвэр 5 жил үр дүнтэй, тасралтгүй ажилласан ажилчдад төлөвлөгөөт жилд компанийн гаргасан, зарласан болон нэмж гаргаж буй хувьцаанаас эзэмшүүлнэ. Үр дүнтэй ажилласан гэх үнэлээмжийг ажлын гүйцэтгэл 75%-иас доошгүй байхыг ойлгоно. Ажилтны ажлын гүйцэтгэлийн хувийг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтооно. Мөн компаний өөрийн андеррайтераар оролцон компаний шинээр болон нэмж гаргаж буй хувьцааг хямдруулсан үнээр авах тохиолдолд компанийн ажилтан ажиллагсадад энэхүү эрхийг мөн адил олгоно. Олон улсын жишгийн дагуу бид цэвэр ашгийнхaa арав хүргэлх хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг жил бүр, балансын үнэлгээгээр ажилтнууддаа тараахаар төлөвлөж байна.

Мөн компани нэмж гаргаж буй хувьцаанаас компанийн ажилтан ажиллагсадын чадварыг дээшлүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтуудад дотоод болон гадаадад хамруулах зэргээр хүний боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллахаар төлөвлөөд байна. Компанийн ахлах менежерүүд болон ажилтнуудыг богино хугацааны гадаад, дотоодын сургалт, семинарт хамруулж мэргэжил дээшлүүлэх арга хэмжээг аван юугаар ч орлуулашгүй компанийн гол баялаг болох хүний нөөцийн асуудалд анхаарлаа хандуулахаар төлөвлөж байна.

**“Евразия Капитал Холдинг УЦК” ХК-ийн Ажилтнуудад хувьцаа эзэмшиүүлэх  
хөтөлбөрийн журам:**



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ УЦК” ХК-ИЙН  
АЖИЛЧДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

**Нэг. Нийтлэг үндсэлэл**

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Евразия капитал холдинг УЦК” ХК( цаашид компани )-ийн хүний иеөсийн хэвийн үйл ажиллагаа хангах, ажилтан ажилчдад компанийнхаа хувьцааг эзэмшиүүлэх тэдний эрх ашгийг хамгаалах, зэрэг харилцааг зохицуулжад оршино.
- 1.2 Энэхүү харилцаанд Монгол улсын Хөдөлмөрийн хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох журам заавар болон энэхүү журмыг дагаж мөрднө.
- 1.3 Энэхүү журамд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор нэмэлт вөрчлөлт оруулна.

**Хоёр. Хувьцаа эзэмших эрх үүсч, хотолбөрийн зохицуулалт**

- 2.1 Тус компанийд эзлжин амралт, овчтэй, чөлөөтэй байсан хугацааг хасаад цэвэр 5 жил үр дүнгэй, тасралтгүй ажилласан ажилтан ажиллагсадад төлөвлөгөөт жилд компанийн гаргасан, зарласан болон нэмжтаграж буй хувьцаанаас эзэмшиүүлнэ.
- 2.2 Үр дүнтэй ажилласан гэх үнэлэмжийг ажлын гүйцэтгэл 75%-иас доошгүй байхыг ойлгоно.
- 2.3 Ажилтины ажлын гүйцэтгэлийн хувийг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтооно.
- 2.4 “Төлөвлөгөөт жил” гэдэг нь ажилчдад хувьцаа эзэмшиүүлэх хотолбөрийн тайлант жилийн нягтлан бодох бүртгэлийн хугацааг хэлнэ. Энэ нь тухайн компанийн санхүүгийн тайлангаа гаргадаг “санхүүгийн жил”-тэй адил байна.
- 2.5 Тус хотолбөрийн төлөвлөгөөт жил нэгдүгээр сарын 1-нээс авранхөрдугаар сарын 31-ний хооронд байна.
- 2.6 Компани ажилчдад хувьцаа олгох хотолбөрийг хэрэгжүүлэхээс бэлэн мөнгө бус зөвхөн хувьцаа олгоно.



- 2.7 Тус компанийн ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр ажилтаныг ажлаа хийж байх үедээ мөнгөө авах боломж олгоно. Хэрвээ компаний нийм хөтөлбөр хэрэгжүүлэх бол энэ журам хүн бурт тэгш үйтчлэх ёстай.
- 2.8 Компани жил бүр ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн дансанд хэр их бэлэн мөнгө болон хувьцаа байгааг харуулсан дансны хуулагыг гаргаж өгнө.
- 2.9 Энххүү журамд заасан болжолыг хангасны дараа ажилтан хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон, тэтгэвэрт гарсан, нас барсан, тахир дутуу болсон эсэхийг үл харгалзан ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн ажилтны дансны гүйлгээг хязгаарлах эрх компанийл үүсэхгүй.
- 2.10 Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн монгийг авах хүртэл ямар нэгэн албан татвар байхгүй байх бөгөөд мөнгө буцаан таталт нь хувь хүний орлого хэмээн үүнээ албан татвар авч тооцогдоно.
- 2.11 Данс нь бүрэн баталгаажихаас өмнө ажилчид ажлын байраа орхих нехцөлд баталгаажиж чадаагүй байгаа хувьцаа нь хасагдаж тооцогдоно. Хасагдсан хувьцааны тоо хэмжээ бусад эрх үүссэн ажилтан ажиллагсадын дансанд хувиарлагдана.
- 2.12 Хэрэв ажиллагсадад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрт хамрагдах эрх үүсэх боловч олгогдож эхлэхгүй байхад буюу олголт эхлэхээс өмнө, ажлаасаа өөрийн хүснэгтээр гарсан, нас барсан, тэтгэвэрт гарах болон тахир дутуугаас болж хөдөлмөрийн чадвараа алдсан, хөдөлмөрийн гэрээгээ цуцласны дараа ердийн тэтгэврийн насанд хурч байгаа бол тухайн нехцөл байдал үүссэн жилийн дараагийн “толөвлөгөөт жилд” ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хувьцаа олголт эхлэх ёстай.
- 2.13 Хэрэв компанийн ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд хувьцаа авахаар мөнгө зээлээд, буцаж гүйцэж төлөөгүй бол, хөдөлмөрийн гэрээгээ цуцалж буй ажилтнуудад өгөх хувьцаа олголт ажилтан компанийд зээлээ төлж дууссаны дараагийн “толөвлөгөөт жил” хүртэл эхлэхгүй байж болно.
- 2.14 Зээлийн эргэн төлөлт нь хийгдэж дуусаагүй тохиолдолд, ажилтан нас барсан бол, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээн дэх хувьцаа олголт тэр даруй эхлэхгүй байж болох бөгөөд харин нас барсаны дараа хуанлийн жилийн эцэст зээлийн төлөлт ямар байгаагаас ул хамааран өв залгамжлах эрх бүхий этгээдэд хувьцаа олгогдож дууссан байх ёстай.

- 2.15 Хэрвээ компани хэлбэрээ өөрчилсөн, татан буугдсан, бусад компанийн зарагдсан тохиолдолд ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр болон **БҮРЛГЭСНӨЙН ХУВЬЦАА №01**
- 2.16 Компани худалдан авах процесс бол цаг кугацаа их шаардагддаг ажил бөгөөд компанийг зарагдсаны дараа ч хэрэв компани өр төлбөртэй бол, тэр бүх асуудал шийдвэгдэж дуустал ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хөрөнгө тусдаа эскров дансанд байршина.
- 2.17 Ихэнх ажилчид хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох үед ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн дансандaa хувьцаатай үлдлэг Эсвэл компани танд хувьцаагаа зarah сонголтыг олгож болох ба энэ тохиолдолд зах зээлийн үнээр компанидаа буцааж 60 хоногийн дотор зarah эрх үүснэ.
- 2.18 Хэрвээ хувьцааны үнэ осне гэсэн хүлээлт байгаа бол дахиад 1 жил хүлээж дахиад 60 хоногийн дотор зarah эрхтэй ба үүнээс хойш зarah эрх үүсэхгүй.
- 2.19 Дээрх хувьцааныхаа мөнгийг ажилтан нэг дор, эсвэл хэсэгчлэн авах боломжтой.
- 2.20 Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн оролцогчид компанийас олгосон хувьцааг уг хөтөлбөрийн журамд өөрөөр тусгашгүй бол хэнд ч зarah боломжтой. Гэхдээ, хэрэв ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компани нь компанийхаа нийт хувьцааны 50 хувийг ажилчиддат эзэмшүүлсэн тохиолдолд ажилчлаасаа хувьцаагаа буцаан зarahыг шаардаж болно.
- 2.21 Зарим нөхцөлд ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрт оролцогчид ажлаа хийж байхдаа ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх боломж байдаг:
- Доор дурдсанаар ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн оролцогчид тодорхой кугацааны дараа өөрийн дэсиг төрөлжүүлж, бэлэн мөнгө эсвэл хувьцааг шууд авах боломж байдаг.
  - Ажил олгогч ажилчдад хувьцаа эзэмшүүлдэх хөтөлбөрийн оролцогч ажилтанд олгосон компанийхаа хувьцаанд шууд ноогдол ашиг тараахаар шийдвэрлэж болно.
- 2.22 Мөн компаний өөрийн андеррайтераар оролцон компаний шинээр болон нэмж гаргаж буй хувьцааг хямдруулсан үзэр авах тохиолдолд компанийн ажилтан ажиллагсалад энхүү эрхийг мен адил олгоно.


**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ УЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ**



## 2.9.7 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### Онөөгийн үйл ажиллагааны нөхцөл байдал

Тус компани нь 2008 оны 8 сард брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах эрх авсан бөгөөд 2009 оны 9 сард андеррайтерийн эрх авсан. Одоогийн байдлаар компани нь зах зээл дээр эзлэх байр сууриа өргөжүүлж харилцагч, үйлчлүүлэгчийн тоогоо нэмэгдүүлэх чиглэлд төвлөрөн ажиллаж байна.



2014 оны байдлаар Евразия Капитал Холдинг нь Монголын Хөрөнгийн Бирж дээр гүйцэтгэсэн хувьцааны арилжааны дүнгээр 9 дүгээрт жагсаж байна. Цаашид тус компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлж илүү олон харилцагчдийг татах замаар зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлж 2016 онд андеррайтерийн зах зээлийн 6%, брокерийн зах зээлийн 3%-ийг хийх төлөвлөгөөтэй байна. Компанийн зүгээс брокер, дилерийн үйл ажиллагааны арилжааны шимтгэлийг бууруулах сонирхолтой байгаа боловч шимтгэлийн ихэнхи хувийг зохицуулах байгууллагууд авч байгаа нь бууруулах боломжийг багасгаж байна. Мөн андеррайтерийн эрх авсантай холбогдуулан бонд болон хувьцаа гаргах замаар санхүүжилт босгох сонирхолтой компаниудтай хамтарч ажиллах бөгөөд хүснэгтэд заасан шимтгэлийн хувь хэмжээг баримталж ажиллана.

*Хүснэгт 21 Цаашид баримтлах шимтгэлийн хувь хэмжээний төсөөлөл*

	2016	2017	2018	2019	2020
Андеррайтинг (анхдагч зах зээл)	3.00%	3.00%	3.00%	3.00%	3.00%
Брокерийн үйлчилгээ	2.00%	2.00%	2.00%	2.00%	2.00%
Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ	2-5%	2-5%	2-5%	2-5%	2-5%

### Орлогын төлөвлөгөө


Зээл, өрийн үнэт цаасын төлбөрт төлсөн мөнгө

Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү

**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр монгон гүйлгээ**
**Валютын ханшийн зөрүү**
**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**

*Монгол, түүнтэй адилтгах хоронгийн эхийн үлдэгдэл*

*Монгол, түүнтэй адилтгах хоронгийн эцсийн үлдэгдэл*

2015/06/30

**СЗХ**  
 он 10,665,110.86  
 5,795,096.00  
 БҮРГЛЭВ  
 № 01  
 753,086.86  
 3,808,504.00  
 308,424.00

103,259,130.69

62,293,599.00

12,089,108.63

6,328,610.00

1,892,000.00

7,845,015.40

66,825.00

12,743,972.66

(92,594,019.83)

25,168,923.01

24,180,613.50

988,309.51

96,248,220.00

(71,079,296.99)

393,718,860.30

392,155,137.50

1,563,722.80

305,232,950.00

305,232,950.00


88,154,507.62

(331,402.68)

(75,518,809.20)

86,657,100.55

11,138,291.35

*Нэмэлт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн нэг салигүй хэсэг болно.*


Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА****1. "ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ" ХК-ийн танилцуулга, үндсэн үйл ажиллагааны талаар**

"Евразия капитал монголиа" ХХК -ийн хувь нийтлүүлэгчийн 2008 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэрээр компанийн дүрэмээ боловсруулж 2008 оны 7 дугаар сарын 21-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлснээр Улсын бүртгэлийн 9019043/35 дугаартай № 5244536, регистртгэй, гэрчилгээ авч гадаадын хөрөнгө оруулалттай "Евразия капитал монголиа" ХХК үүсгэн байгуулагджээ. Энэ компани нь анх байгуулагдах үедээ 57,900.0 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, гадаад худалдаа эрхлэх үйл ажиллагаа явуулах чиглэлтэй Узбекстан улсын иргэн Алишер Джумановын 100 хувийн хөрөнгө оруулалттай байгуулагдсан байна.

Улсын бүртгэлд брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэхээр 2008 оны 9 дүгээр сарын 30-нд бүртгүүлсэн бөгөөд дүрмийн сангийн өөрчлөлтийг 6 удаа хийсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 04-р сарын 10-ны өдрийн 156 тоот тогтоолоор "Ар хуст шунхлай" ХК-нд "Евразия капитал монголиа" ХХК-ийг нэгтгэсэн байна. "Ар хуст шунхлай" ХК-ийн нийт гаргасан 75874 ширхэг энгийн хувьцааг нэгдэж буй "Евразия капитал монголиа" ХХК-ийн хөрөнгөнд ногдох нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,195,018 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлсэн.


"Евразия капитал Монголиа" ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2008 оны 08 сарын 25-нд брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх 3/45 тоот тусгай зөвшөөрөл, 2009 оны 09 сарын 10 өдрийн 184 тоот тогтоолоор Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, 2011 оны 07-р сарын 26 өдрийн 222 тоот тогтоолоор хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг авсан байна.

Тус 2 компани нь 2013 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 156 тоот тогтоолоор нэгдэж оноосон нэрээ "Евразия капитал холдинг" ХК болгон өөрчилсөн. Компанийн үнэт цаасны арилжаа нь 15 брокер дилерийн компаниар явагддаг бөгөөд ҮЦТТТХТ-өөс авсан үнэт цаас эзэмшигчдийн судалгаагаар тус компанийн хувьцааг 50 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

*Санхүүгийн тайлангийн аудит*
*Сүлд-Аудит ХХК*

## 2. АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

“Сүлд-Аудит” ХХК ба “Евразия Капитал Холдинг” ХК-ийн хооронд 2015 оны 01 сарын 05-и<sup>д</sup> байгуулсан “Аудитын ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу бид танай компанийн 2015 оны 06-р сарын 30-наарх санхүүгийн тайланд аудитын шалгалт хийлээ. Бидний аудитын зорилго нь “Евразия Капитал Холдинг” ХК-ийн 2015 оны 06-р сарын 30-наарх санхүүгийн тайлангийн аудитийн ажлын үндэслэл болно.



## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БҮРТГЭСЭН ТУХАЙ

“Евразия Капитал Холдинг” ХК нь Даймонд программыг ашиглаж, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 143 дугаар тогтооолоор батлагдсан “Үнэт цаас гаргагч болон зах зээлийн мэргэжлийн байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн улгэрчилсэн заавар”-ын дагуу бүртгэлээ хөтөлж санхүүгийн тайлангаа гаргасан байна. Санхүүгийн тайлангаа бүртгэхдээ түүхэн өргтийн, орлогод тооцолтын, орлого зардал зохицох, тасралтгүй байх, нэмэлт тодруулгын гэсэн үндэсн зарчмуудыг баримталдаг. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтуудийг Монгол Улсын менгэн тэмдэгт төгрөг, менгөөр илэрхийлсэн.

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

### а. Монгол түүнтэй адилтгах хөрөнгө

Компани менгэн хөрөнгөө *Kass* дахь бэлэн монгол (төгрөг, ам.долларын) ба *банкны харилцах данс* (төгрөг, ам. долларын) гэж ангилан бүртгэдэг.

Гадаад валютыар хийгдсэн гүйлгээг тухайн үеийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэдэг. Гадаад валютын дансын үлдэгдлийг тайлант жилийн эцэс дэх тухайн валютын хаалтын ханшаар тайлагнасан. Албан ханш ба гүйлгээний ханшын зөрүүг “Гадаад валютын ханшийн зорууний олз (гарз)” дансанд бүртгэж орлого үр дунгийн тайланд олз (гарз)-аар тайлагнасан.

## 5. Урьдчилж төлсон зардал, Урьдчилж төлсон тооцоо

Урьдчилан төлсон зардал/тооцоо гэж тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсон зардлыг (даатгал, түрээс г.м.) балансын хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсон зардал гэж үзүүлнэ. Ийм төрлийн зардлыг дараагийн тайлант үеүүдэд зардалл шингээнэ.

### в. Авлага

Авлагыг үүссэн үед нь харилцагч байгууллага болон хувь хүнээр ангилан нэрлэсэн үнээр нь дансанд тусгадаг. Дараа тайлангаар олгосон менгийг авлагаар бүртгэж байна.

### г. Үндэсн хөрөнгө ба түүний элэгдэл

Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглалтын боломжит хугацаа нь хязгаарлагдмал бизнесийн хэвийн нохцолд худалдах зориулалтгүй, үйлчилгээний болон захиргааны

Санхүүгийн тайлансийн аудит


Сүлд-Аудит ХХК

зориулалтаар ашиглагдах элэгдлийн үндсэн дээр өртөг, зардалд анхны өртгөө аажмаар шингээж байдаг биет хөрөнгүүд байна.

Үндсэн хөрөнгийг дотор нь нийтлэг шинж чанар, зориулалтаар нь машин тоног тохөөрөмж тавилга эд хогшил, компьютер түүний дагалдах хэрэгсэл гэж ангилна.

Үндсэн хөрөнгийг шулуун шугамын арга ашиглан, ашиглалтын хугацааных нь туршид элэгдүүлсэн. Хөрөнгийг бүрэн элэгдүүлж дусах хугацаа дараах байдлаар харуулав.

Машин тоног тохөөрөмжийг  
Тавилга эд хогшилыг  
Компьютер ба түүнтэй адилтгах хөрөнгийг



#### d. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэдэг байна. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг хөрөнгийн онцлог шинж чанарыг харгалзан тодорхойлох ба шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

#### e. Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол улсын “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн дагуу ажиллагсадад олгохоор тооцсон цалингаас 10%, байгууллага 11% нийт 21%-иар нийгмийн даатгалын шимтгэл төлдөг.

#### ё. Татвар тооцолт

**Аж ахуйн иэгжийн орлогын албан татвар** - Монгол улсын “Аж ахуйн иэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн дагуу аж ахуйн иэгж байгууллагууд 3 тэрбум хүртэл тогрогийн татвар ногдуулах орлогод 10%-иар, 3 тэрбум төгрөгөөс дээш орлогод 25%-иар аж ахуйн иэгжийн орлогын албан татвар төлдөг. Компани нь татвар ногдуулах орлогод 10%-иар аж ахуйн иэгжийн орлогын албан татвар төлж байгаа болно.

**Хувь хүний орлогын албан татвар** - Монгол улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-иар ажилтнуудын цалингаас 10%-р татвар сүүтган авч төлдөг.

#### ж. Орлогод тооцолт

Үндсэн үйл ажиллагааны орлого нь брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын менежмент, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний, орлого зэрэгээс бурдэнэ. Үйлчилгээ үзүүлснээс орох орлогыг ихэнхдээ уг үйл явдал болсон тэр үед нь орлогоор хүлээн зөвшөөрнө. Үндсэн бус үйл ажиллагааны орлогод үндсэн хөрөнгө, бусад хөрөнгө борлуулсны орлого, гадаад валютын ханшийн тэгшигтэлийн, төрөл бүрийн алданги болон гэнэтийн ажил гүйлгээнээс орох орлого орно.

#### и. Өр төлбөр

Өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд бусдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага бөгөөд ирээдүйд төлөх бодит өртгөөрөө бүртгэлд тусгагддаг.

#### й. Эздийн өмч

Эздийн өмч буюу капитал нь оруулсан капитал болон олсон капиталын нийлбэр юм. Эздийн өмч нь тухайн байгууллагын нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүйтэй тэнцүү байна.

Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

к. Зардал

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбогдон гарсан бүх зардлыг эрхийн дүнгийн тайланц тусгадаг бөгөөд эдгээр зардлыг аккруэль сууриар бүртгэдэг.

### **5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДРУУЛГА**

#### **5.1 НИЙТ АКТИВ ТҮҮНИЙ БҮТЭЦ, АКТИВЫН ЧАНАР**

“Евразия капитал холдинг” ХК -ийн активын бүтцийг тодорхойлох ажлын хурээнд

Нийт активын бүтэц 2015 оны 6-р сарын 30-ны байдлаар дараах байдалтай байна.

ХӨРӨНГӨ	2014/12/31	2015/06/30	/төгрөгөөр/ Өөрчлөлт
<b>1 Эргэлтийн хөрөнгө</b>			
1.1 Мөнгөн хөрөнгө	86,657,100.55	11,138,291.35	(75,518,809.20)
1.2 Бусад санхүүгийн хөрөнгө -Арилжаалах үнэт цаас -Хувьцаагаархи хөрөнгө оруулалт -Үнэт цаасны бодит үнэ цэнийн тохируулга	2,316,092,258.77 1,810,595,673.00 306,235,600.00 199,260,985.77	2,316,002,943.16 1,810,506,357.39 306,235,600.00 199,260,985.77	(89,315.61) (89,315.61)
1.3 Авлага	86,540,715.64	157,050,055.70	70,509,340.06
1.4 Бараа материал	1,461,517.21	1,461,517.21	-
1.5 Урьдчилж толсон зардал/ тооцоо	6,121,500.00	6,258,000.00	136,500.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,496,873,092.17</b>	<b>2,491,910,807.42</b>	<b>(4,962,284.75)</b>
<b>2 Эргэлтийн бус хөрөнгө</b>			
2.1 Үндсэн хөрөнгө	59,738,103.04	54,475,249.30	( 5,262,853.74)
2.2 Биет бус хөрөнгө	1,906,017.92	1,615,378.98	( 290,638.94)
2.3 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	61,644,120.96	56,090,628.28	(5,553,492.68)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,558,517,213.13</b>	<b>2,548,001,435.70</b>	<b>(10,515,777.43)</b>

2015 оны эхний хагас жилийн нийт хөрөнгийг 2014 онтой харьцуулбал нийт хөрөнгө 10.5 сая төгрөгөөр буурсан, авлага 70,509.3 сая төгрөгөөр үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгийн 97.8% нь эргэлтийн хөрөнгө, 2.2% нь эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн аюулт

Судл-Аудит ХХК

**5.1.1. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ**

Бэлэн мөнгөний тооллогын бүртгэлээр төгрөгийн кассын үлдэгдэл 6,929,184.66 төгрөг байгаа нь кассын тооллогын акт, гүйлгээ баланс, еронхий журналын дунтгэй тохирж байна.

Д/д	Үзүүлэлт	2014/12/31	2015/06/30	Валют	Тулгар баталтадажуулалтаар
1	Кассанд байгаа бэлэн мөнгө	4,670,247.66	6,929,184.66		6,929,184.66
	Кассанд байгаа бэлэн мөнгө/доллар/		128,357.92	65.37	128,357.92
	<b>Бэлэн мөнгө</b>	<b>4,670,247.66</b>	<b>7,057,542.58</b>	<b>65.37</b>	<b>7,057,542.58</b>
1	ХХБ /MNT/ 404210685	1,091,949.07	3,276,534.08		3,276,534.08
2	ХХБ /MNT/ 487000015	360,291.60	595,887.60		595,887.60
3	ХХБ /USD/ 404210686	771,397.46	171,536.60	87.36	171,536.60
4	ХХБ /MNT/ 487000014	10,265,153.87	263,46		263.46
5	ХХБ /EUR/ 487000014	24,584.82	18,455.97	8.42	18,455.97
6	ҮЦТТТХТ төв	69,473,476.07	18,071.06		18,071.06
	Харицахад байгаа мөнгө	81,986,852.89	4,080,748.77		4,080,748.77
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>86,657,100.55</b>	<b>11,138,291.35</b>	<b>95.78</b>	<b>11,138,291.35</b>


**5.1.2. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СЭЖИГТЭЙ БОЛОН МӨНГӨН ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, тухайн компанийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай дотоод журам, Харицагчийг танъяж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай дотоод журамд заасны дагуу Санхүүгийн мэдээллийн албанад сэжигтэй гүйлгээний талаар, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзсэн эсхүл 20.0 сая төгрөг /туүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дунтгэй гүйлгээнүүдийг бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн маягтын дагуу бэлтгэн тогтмол мэдээлж байх үүрэгтэй. Үүний дагуу тус компанийн банкнуудын дансдын гүйлгээнүүдийг хянахад дараах гүйлгээг санхүүгийн мэдээллийн албанад 2015 оны 02 сарын 12-ны өдрийн албан э-майлээр мэдээлсэн байна.

Үүнд:

Худалдаа хөгжлийн банк Валютын гүйлгээнээс

Д/д	Огноо	Мөнгөний нэгж	Гүйлгээний утга	Орлогын гүйлгээний дүн	Зарлагын гүйлгээний дүн
1.	2015/02/12	Доллар	Хөрөнгө оруулалт	149,999.0	0.00

**5.1.3. АРИЛЖААЛАХ ҮНЭТ ЦААС**

2015 оны 06-р сарын 30-ны байдлаархи санхүүгийн тайлангаар арилжаалах үнэт цаасны үлдэгдэл 1,810,506.4 мянган тогрогийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**5.1.4. ХУВЬЦААГААРХИ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

Тухайн оны эхэнд хувьцаагаархи хөрөнгө оруулалт 306,235.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайллагнагдсан ба тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын шинжтэй ямар нэгэн гүйлгээ тараагүй байна.

**5.2 АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ТҮҮНИЙГ ЗӨВРӨЗХИСТОЙ ЗАРЦУУЛЖ БАЙГАА ЭСЭХ**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11 дэх заалтын дагуу брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувис дошигүй хувьтай тэнцэх хэмжээгээр “Үнэт цаасны болзошгүй эрсдэлээс хамгаалах сан” байгуулах ёстой бөгөөд тус компани нь эрсдлийн сангаа байгуулаагүй байна.


**5.3 ДАНСНЫ АВЛАГА**

*Авлагын үлдэгдэл - нэр төрлөөрөө* /мян.төг/

Үзүүлэлт	2014/12/31	2015/06/30
Хувь хүмүүсээс авах авлага	42,696.6	113,379.0
Компани хоорондын авлага	1,400.0	1,535.9
Байгууллага хоорондын тооцоо	41,883.5	41,883.5
Татварын авлага	360.5	51.6
Дараа тайлангийн тооцоо	200.0	200.0
<b>Авлагын дүн</b>	<b>86,540.7</b>	<b>157,050.0</b>

2014 онд өмнөх оноос нийт авлагын үлдэгдэл 70,509.3 мянган төгрөгөөр буюу 81.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээр авлагууд нь төлөгдөх хугацаандаа байгаа авлагууд ба нийт авлагын 97.8 хувийг эзлэж байгаа Комалдинийн 37,532.3 мянган төгрөг, Урвон Ресорсес ХХК-ийн 41,883.5 мянган төгрөгийн авлагуудын үлдэгдэл нь тулган баталгаажуулах захидлаар баталгаажсан болно.

**5.4 БАРАА МАТЕРИАЛ**

/мян.төг/

№	БМ-ын төрөл	2014/12/31	2015/06/30
1	Хангамжийн материал /агуулах/	1,461.5	1,461.5
	<b>Бараа материалын дүн</b>	<b>1,461.5</b>	<b>1,461.5</b>

**5.5 УРДЧИЛГАА ТӨЛБОРҮҮД**

/мян.төг/


№	Урьдчилгаа төлбөрийн ангилал	2014/12/31	2015/06/30	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	Урьдчилж төлсөн зардал	6,121.5	6,258.0	136.5	102.2
	<b>Дүн</b>	<b>6,121.5</b>	<b>6,258.0</b>	<b>136.5</b>	<b>102.2</b>

Тухайн оны эхний үлдэгдэл 6,121.5 мянган төгрөг нь 2013 онд Ар хуст шунхтай ХК-д Евразия Монголия ХХК-ийг нэгтгэх үеийн санхүүгийн тайландаа НӨАТ-ын өглөгийг

## Санхүүгийн тайлангийн аудит

Судл-Аудит ХХК

Урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн байгаа ба энэ өглөг нь Евразия капитал холдинг ХК-ийн санхүүгийн тайланд тусгагдаагүй байсан учир үлдэгдэлий тайлагнагдсан байна. 136.5 мянган төгрөг нь ҮЦТТХТСийн нэхэмжлэхээр төлсөн хадгаламжийн гэрээний үнэ болон тархалт судалгааны тэмдэгтийн хураамж болно.

**5.6 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГО**

**A.Үндсэн хөрөнгө:**

Үзүүлэлт	Тавилга эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Компьютер дагалдах хэрэгсэл	/мян.төг/
ӨРТӨГ 2015 оны 01 сарын 01-нээрх үлдэгдэл	25,221.9	41,309.9	11,691.1	78,222.9
Нэмэгдсэн Хасагдсан				
<b>2015 оны 06 сарын 30-иаарх үлдэгдэл</b>	<b>25,221.9</b>	<b>41,309.9</b>	<b>11,691.1</b>	<b>78,222.9</b>
<b>ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ</b> 2015 оны 01 сарын 01-нээрх үлдэгдэл	4,440.5	7,228.1	6,816.3	18,484.9
Нэмэгдсэн Хасагдсан	1,284.7	2,047.4	1,930.7	5,262.8
2015 оны 06 сарын 30-иаарх үлдэгдэл	5,725.2	9,275.5	8,747.0	23,747.7
<b>ДАНСНЫ ЦЭВЭР ҮНЭ</b> <b>2015 оны 06 сарын 30-иаарх үлдэгдэл</b>	<b>19,496.7</b>	<b>32,034.4</b>	<b>2,944.1</b>	<b>54,475.2</b>

Тайлангийн хугацаанд татварын хуулийн дагуу ашиглалтын хугацааг баримтлан 23,747.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

**B.Биет бус хөрөнго**

	2014/12/31	2015/06/30
Программ хангамж	1,906.0	1,615.4
<b>Биет бус хөрөнгийн дун</b>	<b>1,906.0</b>	<b>1,615.4</b>

Арилжааны vibro программ, санхүүтийн тайлан бэлтгэдэг Даймонд программ хангамж уудыг биет бус хөрөнгөөр бүртгэж гэрээний дагуу 5 жилээр элэгдүүлж байна.

**5.7 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**
**Өглогийн үлдэгдэл - иэр төрлөөр**

/мян.төг/

Үзүүлэлт	2014/12/31	2015/06/30
Дансны өглөг	714,131.9	714,131.9
Хувь хүмүүст өгөх өглөг	1,840.0	29,973.6
Цалингийн өглөг	998.4	998.4
ААНОАТ-ын өглөг		98.8

## Санхүүгийн тайллангийн аудит

Сүлд-Аудит ХХК

ХХОАТатварын өглөг	300.2
НДШ-ийн өглөг	151.5
Бусад бодино хугацаат өглөг	58,817.0
<b>Өглөгийн дүн</b>	<b>717,279.7</b>

СЗХ 804,472.3

ОН САР АДЫГА

БҮРЛГЭВ

№ 1

Тайлант хугацаанд дансны өглөг өмнөх оноос 87,192.6 мянган төгрөгөөр нормалсан байна.  
Дансны өглөг 714,131.9 мянган төгрөг нь харилцагчийн хувьцаа худалдан авахаар шилжүүлсэн өглөг байна.

**6. ОРЛОГО**
**6.1. Нийт орлогын бутэц 2015.06.30-ны байдлаар дараах байдалтай байна.**

№	Үзүүлэлт	2015.06.30-ны байдлаар	/мян.төг/ Нийт дунд эзлэх хувь
1	Үндсэн үйл ажиллагааны орлого		
1.1	Брокер дилериин үйл ажиллагааны орлого	991,086.86	15.2%
2	Үзүүлсэн ажил үйлчилгээний борлуулалт		
2.1	Үзүүлсэн ажил үйлчилгээний орлого	5,531,00.00	84.8%
	<b>Нийт орлогын дүн</b>	<b>6,522,086.86</b>	<b>100%</b>

Тайлант оны орлого нь брокер дилериин үйл ажиллагааны орлого, үзүүлсэн ажил үйлчилгээний орлогоо тус тус бүрдэж байна. Бүтцийн хувьд авч үзвэл:

- Үндсэн үйл ажиллагаа /брокер дилер, андеррайтер, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээний орлого 15.2 %
- Үзүүлсэн ажил үйлчилгээний орлого 84.8%-ийг эзэлж байна.

**6.2. Компанийн нийт орлого, зарлага, үр дүн 2015.06.30-ны байдлаар дараах байдалтай байна.**

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2015.06.30-ны байдлаар	/мян.төг/
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>			
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,522.08	
2	Борлуулсан бүтээгдхүүний өртөг	89.31	
3	<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>6,432.77</b>	
4	Хүүгийн орлого	988.30	
5	Бусад орлого	40.00	
6	Ерөнхий ба удирдлагын зардал	98,772.06	
7	Бусад зардал	6,531.36	
8	Гадаад валютын ханшийн зорууний олз ( гарз )	232.82	
9	Татвар толохийн өмнөх ашиг (алдагдал)	(97,609.53)	
10	Орлогын татварын зардал	98.83	
11	Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)	(97,708.36)	
12	Тайлант үсийн цэвэр ашиг (алдагдал)	(97,708.36)	



## Санхүүгийн тайлансийн аудит

Сүлд-Аудит ХХК

2015 оны эхний хагас жилд тухайн байгууллага нь 173,555.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Оссөн дүнгээр балансын үзүүлэлтийг хараад хуримтлагсан алдагдал 405,808.1 мянган төгрөг байгаа нь цаашид алдагдлыг бууруулахад анхаарч ажиллах хэрэгтэй байна.

**7. ДУРМИЙН САНГИЙН БҮРДЭЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

“Евразия капитал холдинг” ХК нь анх 1,874.2 сая төгрөгийн дурмийн сантайгаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба тайлант жилд компанийн дүрэмд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна. 2014 оны 06-р сарын 30-ны байдлаар тус компанийн дурмийн сангийн бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн дараах бүтэцтэй байна.

№	Хувь нийлүүлэгчдийн нэр	Эзэмшиж буй хувьцаа /ширхэгээр/	Дурмийн санд эзлэх хувь
1	Евразия капитал лимитед ХХК	2,195,018	ширхэг
2	Урвон ресурсес ХХК	22,000	ширхэг
3	Г.Оюунболд	22,400	ширхэг
4	Б.Энхжаргал	3,087	ширхэг
Дүн		2,242,505	ширхэг
			100%

Бусад 46 хувьцаа эзэмшигчид нь жижиг хувьцаа эзэмшигчид байх бөгөөд 1-200 ширхэг хувьцааг тус тус эзэмшиж байна.


**8. ЗАРДАЛ**

		2014/12/31	/мян.төгр/ 2015/06/30
1	Цалингийн зардал	166,713,942.27	70,791,962.56
2	НДШ-ийн зардал	18,326,632.68	7,802,091.89
3	Засвар үйлчилгээний зардал	64,000.00	552,000.00
4	Бичиг хэргийн зардал	741,170.00	283,350.00
5	Албан томилолтын зардал	74,000.00	
6	Ашиглалтын зардал	379,395.00	
7	Хангамжийн материалын зардал	528,000.00	289,330.00
8	Шуудан холбооны зардал	14,588,611.00	6,861,090.00
9	Шатахууны зардал	3,473,403.00	1,340,000.00
10	Бусадаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	8,500,000.00	2,453,000.00
11	Элэгдлийн зардал	11,199,032.20	5,553,492.68
12	Түрээсийн зардал	11,085,920.00	814,680.00
13	Сургалт семинарын зардал	3,800,800.00	300,000.00
14	Татварын зардал	71,260.00	71,260.00
15	Бусад зардал	6,641,304.96	1,659,805.00
16	Тээврийн зардал	2,138,100.00	
Үйл ажиллагааны зардлын дүн		248,325,571.11	98,772,062.13

Нийт зардлын дүнд нь цалингийн зардал 71.7 хувь, НДШ-ийн зардал 7.9 хувь, шуудан холбооны зардал 6.9 хувь, элэгдлийн зардал 5.6 хувь, бусадаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс 2.5 хувь, бусад зардал 1.7 хувь, шатахууны зардал 1.5 хувь, түрээсийн зардал 0.8 хувь, засвар үйлчилгээний зардал 0.5 хувь, бичиг хэргийн зардал 0.3 хувь, хангамжийн материалын зардал 0.3 хувь, сургалт семинарын зардал 0.3 хувь, татварын зардал 0.07 хувийг тус тус эзэлж байна.

*Санхүүгийн тайлангийн аудит**Сүлд-Аудит ХХК***9. АУДИТОРЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

Бид “Евразия капитал холдинг” ХК-ийн 2015 оны 06-р сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, санхүүгийн зохицуулах хорооноос тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь СТОУС, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан, аргачлал, заавар журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд алдаагүй үнэн, зөв илэрхийлж гаргасан байна гэж үзээд стандарт дүгнэлт өглөө.

**10. ӨМНӨХ АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Сүлд-Аудит” ХХК-иар санхүүгийн тайлангийн аудит хийлгэж стандарт дүгнэлт гаргасан байна.

**11. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР**

Тус компани нь 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд болзошгүй өр төлбөртэй холбоотой ажил гүйлгээ гараагүй байна.

**12. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ГҮЙЛГЭЭ**

Тайлант хугацаанд холбоотой талын гүйлгээ гараагүй байна.

**УДИРДЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ**

“Евразия капитал холдинг” ХК-ийн 2015 оны 06-р сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд аудитын ажлын баримтууддаа үндэслэн танай байгууллагын нягтлан бодох буртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд тус дөхөм болох үүдиээс дараах дүгнэлт, зөвлөмжийг өгч байна. Үүнд :

**1. Эредлийн сангийн талаар****Бодит байдал**

“Үнэт цаасны болзошгүй эрсдэлээс хамгаалах сан” байгуулах ёстой бөгөөд тус компани нь эрсдлийн сангаа байгуулаагүй байна.


**Зөвлөмж**

- Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 507-р тогтооюур батлагдсан Зохицуулалттай этгээдийн эрсдлийн сангийн тухай журам, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11 дэх заалтын дагуу брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувиас доошгүй хувьтай тэнцэх хэмжээгээр Үнэт цаасны болзошгүй эрсдэлээс хамгаалах санг байгуулахыг зөвлөж байна.

“СҮЛД-АУДИТ” ХХК-ийн Аудитын ажлын баг



**3.2 Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэсэн тухай мэдээлэл, бизнесийн үнэлгээний талаарх үнэлгээний байгууллагын дүгнэлт**



Монгол улс  
Улаанбаатар-38  
Самбуугийн гудамж-11

Утас: 325175 (a)  
Факс: (976-11)-325127  
Вэб хаяг : [UNELGEENHITUVMN.COM](http://UNELGEENHITUVMN.COM)

ЕВРАЗИА КАПИТАЛ  
ХОЛДИНГ ИМК  
EURASIA CAPITAL  
HOLDING JSC

"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьцааны ханшийн үзүүлээ

Тайлан гаргасан он, сар, өдөр : 2015.07.21.

Захалагчийн нэр : "Евразия Капитал Холдинг" ХК-ийн Гүйцэтгэх зорилал  
Г.Оюунболд



**"ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ" ХК-ИЙН НЭГЖ ХУВЬЦААНЫ  
ХАНШИЙГ ҮНЭЛСЭН ТУХАЙ ТАЙЛАН**

**Нэг. Үзүүлээний ажлын зорилго**

"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьцааны ханшийг 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тодорхойлоход энхүү үнэлгээний ажлын зорилго оршино.

**Хоёр. Үнэлгээ хийсэн он, сар, өдөр**

Нэгж хувьцааны ханшийг тодорхойлохын тулд тус компанийн хөрөнгө болон үйл ажиллагааных нь талаар 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дэлгэрэнгүй мэдээлэл авч судалж үзсний үндсэн дээр үнэлгээг хийж тайланг бичив.

**Гурав. Компанийн талаархи мэдээлэл**

**А. Товч танилцуулга**

2013 онд "Евразия Капитал Монголиа" ХХК, "Архуст Шунхлай" ХК-тай нэгдсэнээр "Евразия Капитал Холдинг" хувьцаат компани үүсгэн байгуулагдсан. Тус компани нь Монголын Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл олгодог брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн тусгай зөвшөөрлийг эзэмшидэг.

Тус компани нь 1996 оны 04 сарын 28-ны өдрийн 01 тоот тогтоолоор таван хошуу мал, цаа буга, сүүний фермерийн чиглэлээр үндсэн үйл ажиллагаа эрхлэх, хүнсний ногоо, үрслэг тариалалт, үр тариа олон бусад ургамал тариалалт, зочид буудал, амралтын газар, бөөний худалдааны чиглэлээр туслах үйл ажиллагаа явуулахаар "Архуст шунхлай" ХК нэргээсээр үүсгэн байгуулагдсан.

Анх 100 /нэг зуу/ төгрөгийн нэргэсэн үнэтэй 75,874 /далан таван мянга найман зуун далаан дөрөв/ ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд 7.587.400 /долоон сая таван зуун наян долоон мянга дөрвөн зуу/ төгрөгийн хувь нийлүүлсн хөрөнгөтэй байсан.

“Евразия Капитал Холдинг” ХК-ийн нэгж хувьцааны ханшний үнэлгээ

Санхүүгийн зохицуулах хороо 2013 оны 04-р сарын 10 өдрийн 156 тоот тогтоолоороо “Ар хуст шунхтай” ХК-ид “Евразия капитал монголиа” ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөн “Ар хуст шунхтай” ХК-ийн нийт гаргасан 75874 ширхэг энгийн хувьцааг нэгдэж буй “Евразия капитал монголиа” ХХК-ийн хөренгөд ноогох нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,195,018 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэхийг зөвшөөрсон.

“Евразия капитал Монголиа” ХХК нь 2008 оны 08 сарын 25 ид брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх 3/45 тоот тусгай зөвшөөрөл, 2009 оны 09 сарын 10 өдрийн 184 тоот тогтоолоор Андеррайтерийн үйл ажиллагаа, 2011 оны 07-р сарын 26 өдрийн 222 тоот тогтоолоор хөренгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан үнэт цаасны зах зээлд нэр хүндтэй томоохон компаниудын нэг байсан.

Нэгдсэний дараа компани оноосон нэрээ “Евразия Капитал Холдинг” ХК болгон өөрчилсөн. Мөн компанийн хувьцаа 2,270,892 ширхэг, үйл ажиллагааны чиглэл хөренгө оруулагчдад үнэт цаас худалдан авахад нь зуучлах, зах зээлийн үнэ ханш болон хувьцаат компаниудын талаарх мэдээллийг хүргэх, судалгааны бүтээл бэлтгэн боловсруулж хэвлэн тараах, мөн хөрөнгө оруулагчдад хөренгө оруулалтын зөвлөгөө өгөх, IPO (initial public offering) буюу олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгох үйл ажиллагаа хийх, нэмэлт хувьцаа гаргах ажиллагаа, өрийг хувьцаагаар солих, хувьцаа эзэмшигчдийн курал зарлан хуралдуулах зэрэг болж бүрэн өөрчлөгдсөн.

Гадаадын хөренгө оруулалтын сан, гадаадын томоохон хөренгө оруулагчидтай хамтран ажилладаг. Олон улсад тэр дотороо Хонг Конг, Дубай, Нью Йорк, Женев зэрэг хотуудад зохион байгууллагддаг хөренгө оруулалтын чуулга уулзалтуудад байнга оролцдог.

#### Б. Удирдлага, бүтэц зохион байгуулалт

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь эзлжит болон эзлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ байна. ТУЗ-ын хурлаас оролцсон гишүүдийн олонхийн саналаар ТУЗ-ын даргыг сонгодог бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, шийдвэр гаргах, түүний биелэлтэнд хяналт тавих үүрэгтэй.

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдах бөгөөд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулна.

"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нотж хувьцааны ханшийн үзэлсөн

-3-

**Компанийн хувьцаа ээмшигчдийн иэр, эзэмшиж буй  
хувьцааны тоо ширхэг**


д/д	Эзэмшигчийн иэр	Хувьцааны тоо ширхэг
1	Гомбо овогтой Оюунболд	22,400
2	"Урбан Ресорес" ХХК	22,000
3	Бавуу овогтой Энхжаргал	ОН 3,087 өдөр
4	"Евразия капитал Лимитед" компани	2,195,018
5	"Евразия капитал холдинг" компани	25,038
6	Бусад 47 жижиг хувьцаа ээмшигчид	№ 3,349
		2,270,892

Гомбын Оюунболд: Гүйцэтгэх захирал

"Евразия Капитал Холдинг" ХК-ний гүйцэтгэх захирлаар Г.Оюунболд ажиллаж байна. Тэрбээр МУИС-н Хууль Зүйн Сургууль, Гадаад хэлний "Оюу" дээд сургуулийг тус тус төгссөн. Хууль зүй болон хэл шинжлэлийн бакалавр зэрэгтэй. Тэрбээр өмнө нь Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албанад хяналт шалгалтын мэргэжилтэн, "Улаанбаатар Импекс" ХХК-д болон "Улаанбаатар Тоног Төхөөрөмж" ХХК-д Гүйцэтгэх захирал, Анод банкны Нууцлал, Аюулгүйн албанад мэргэжилтэйр тус тус ажиллаж байсан ажлын туршлагатай. Оюунболд нь Англи хэлний мэдлэгтэй.

Одоогоор "Евразия Капитал Холдинг" нь гүйцэтгэх захирал 1, нягтлан бодогч 1, дилер 1, логоод хяналтын ажилтан 1, хоренгэ оруулалтын зөвлох 1, шинжээч 2, үнэт цаас хөгжлийн менежер 1, брокер 1 ба нийтдээ 8 ажилчинтай үйл ажиллагаагаа явуулж байна.

**Компанийн бүтэц**



4




"Евразия Капитал Холдинг" ХК-ийн илгэж хувьцааны ханшийн үнэлгээ



## В. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өвөөгийн байдал

### -Брокерийн үйл ажиллагаа

"Евразия Капитал Холдинг" ХК нь харилцагч, хөрөнгө оруулалтадаа зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдах үйл ажиллагаагаар түргэн шуурхай гүйцэтгэсээр ирсэн ба илүү чанартай үйлчилгээ үзүүлэхийн ямаргүй ажилладаг. Манай компани өөрийн харилцагчид болон олон нийтэд үнэт цаасны үнэ ханшийн үнэн бодит мэдээ, мэдээлэл, судалгаа, шаардлагатай бусад зөвлөгөөг хууль, журмын дагуу хүргэж байна.



### -Цахим брокерын үйлчилгээ

Манай компанийн харилцагчид цахим брокерын үйлчилгээг ашиглаж дэлхийн аль ч өнцгөөс утас, факс, и-мэйл ашиглан цаг хугацаа, орон зайнаас үл хамаараан арилжаанд оролцох боломжтой юм. Энэхүү үйлчилгээ компани нь тусгай зөвшөөрлүүдээ авсан одроос хэрэгжүүлж байгаа бөгөөд гадаад дотоод харилцагчидад шуурхай хурдан үйлчилгээг үзүүлдэг.

### -Андерраторийн үйл ажиллагаа

Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос андерраторийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг эзэмшиж: 2014 онд "Дархан Хүнс" ХК-ийн ерийт хувьцаагаар солих, нэмэлт хувьцаа гаргах үйл ажиллагааны андерратораар ажиллаж амжилттай хэрэгжүүлсэн.

### -Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа

"Евразия Капитал Холдинг" ХК нь хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрлийг авснаас хойш дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагч нарт Монгол Улсын хорөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулах, хөрөнгө босгох үйл ажиллуудын талаар өнөө хүртэл зөвлгөө өгөж ирсэн.

### -Мэдээлэл, судалгаа

Бид өөрийн харилцагч нартаа өдөр тутмын арилжааны мэдээ, долоо хоногийн тойм зэрэг арилжааны мэдээ хүргэхээс гадна хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниуд, эдийн засгийн болон улс төрийн судалгаануудыг цахим болон хэвлэлмэл байдлаар хүргэж байна.

Манай судалгаа, анализын баг хөрөнгө оруулагчид, томоохон харилцагчиддаа зориулан Монголын эдийн засаг болон хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниудын талаарх мэдээлэл, тайлан, судалгааг олон улсын стандартад нийтийн бэлтгэж, харилцагчдад тогтмол хүргэн ажилладаг.


"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьшаны ханшийн үнэлгээ

-5-

Судалгаа шинжилгээний онолын аргачлалыг Монголын хөрөнгийн зах зээлд тохиуулан өөрчлөн, бусад хөгжиж буй улсуудын компаниудтай харьцуулалт хийж (comparably analysis), өөрсдийн дүгнэлтийг өгч хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргахад нь тусалдаг.

#### -Багцын арилжаа

Манай компани хувьцаат компаниудын тодорхой хувийг эзэмшиж сонирхолтой санхүүгийн ондөр чадамж бүхий томоохон харилцагчдыг хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчидтэй зуучлах болон өөрийн эзэмшиж буй хувийг борлуулах сонирхол бүхий хувьцаа эзэмшигчдэд тухайн үнэт цаасыг худалдан авах хөрөнгө оруулагч олох замаар багцын арилжааг зохион байгуулдаг.



#### -Back Office

Монголын Хөрөнгийн Бирж болон Лондонгийн Хөрөнгийн биржийн хамтын ажиллагааны гэрээний дагуу 2012 оны 7 сард Millennium IT (MIT) системийг Монголд извтрүүлсэн ба арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээг Клиринг банкуудад шилжүүлсэн. Ийнхүү шинэ бүтэц бий болсноор брокерийн компаниуд үнд өөрийн үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах шаардлагатай болоод байгаа. "Евразия Капитал Холдинг" компани 2009 онд өөрийн бүтцэд шинээр Back office албыг бий болгон төлбор тооцоо, T+3 арилжаа, бүртгэл мэдээлэл, хяналтын үүргийг гүйцэтгэдэг ба харилцагчийн захиалгыг биелүүлэх, арилжаа хэвийн явагдах бүхий л иехилийг зах зээлийн журам, шаардлагын дагуу ханган ажиллаж ирсэн.

2015 оны 2 дугаар сарын 25-ний өдрийн байдлаар Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 237 компани бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс 89 компани II дугаар антлагалд, 148 компани нь III дугаар англалд бүртгэлтэй байна. 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 255 удаагийн арилжаагаар 137 компанийн 51.7 сая ширхэг хувьцааг 24.2 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаасны 9 удаагийн арилжаагаар 375.5 мянган ширхэг үнэт цаасыг 36.1 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 60.4 тэрбум төгрөгийн түүлээ хийгдсэн. 2014 оны хувьцааны арилжаа 2013 онтой харьцуулахад -75.2% буурсан байна. 2014 оны зах зээлийн үнэлгээ 1 их наяд 442.6 тэрбум төгрөг байсан бөгөөд 2013 оныхоос -13.7% буурсан.

"Евразия Капитал Холдинг" ХК нь Монголын үнэт цаасны зах зээл дээр Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн цогц үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу олон нийгэл хүргэдэг, Монголын хөрөнгийн биржийн гишүүн байгууллага юм. "Евразия Капитал Холдинг" ХК нь гадны болон дотоодын харилцагч хувь хүн, байгууллагад хөрөнгийн зах зээл дээрээс үнэт цаас худалдах, худалдан авахад зуучдах, хөрөнгө

"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьцааны ханшийн үнэлгээ

босгох, хөрөнгө оруулах тал дээр мэргэжлийн зөвлөгөө егөх цогц үйлчилгээг олон улсын стандартын дагуу түргэн шуурхай хүргэдэг.

#### Дөрөв. Хөрөнгийн зах зээлийн шинжилгээ

##### A. Хөрөнгийн зах зээлийн байдал

Монголын хөрөнгийн биржийн Топ-20 индекс 2012 онд -16%, 2013 онд -7%, 2014 онд -9%-иар буурсан. Монгол улсын эдийн засгийн хөгжилтөнгөрөн онд урьд жилүүдэсээ буурч, мөн уул уурхайн салбар цаашид хөгжих хамлагага нь тодорхой бус болсон нь төрийн байгууллагуудаас гаргаж байгаа хууль дүрэм журам нь гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд сөрөг нөлөө үзүүлсэн. Гэвч эдийн застийн хөгжил ирээдүйд осож уул уурхай болон бусад салбарууд хурдтай хөгжих нь тодорхой юм. 2010 онд Монголын Хөрөнгийн Биржийт менежментийн хувьчлалд оруулахаар болсон нь манай хөрөнгийн биржийн хөгжлийн талаарх хүлээндтийг нилээд зерэг тал руу хандуулсан үйл явдал болсон юм. 2011 онд Лондонгийн Хөрөнгийн Биржтэй Төрийн Өмчийн Хороо стратегийн хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан нь дотоодын болоод гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд таатай мэдээ байсан.

2012 оноос МХБ-ыг шинэчлэх ажлын хүрээнд Millennium IT системийг суурьшуулж шинэ системээр ажиллаж эхлээд байна. Шинэчлэлийн хүрээнд арилжааны журмууд шинэчлэгдэж, төлбөр тооцооны систем T+3 өдөрт цаашид шилжихтэй холбоотойгоор Брокерийн компаниудад илүү өндөр шаардлага тавьж эхэлсэн нь зах зээлийн хөгжилд цаашид томоохон тулхэц болно.

Монголын хөрөнгийн зах зээл дээр нийт 62 компани үйл ажиллагаагаа явуулж байна. 2011, 2012, 2013 онд олон шинэ компаниуд байгуулагдаж, Хөрөнгийн бирж дээр судал авсан нь Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах сонирхол өндөр байгааг харуулж байна.

Нийт зах зээлийн үнэлгээ 2012 оны эцэст 1,799 тэрбум төгрөг байсан бол 2013 оны эцэст 1,670 тэрбум төгрөг болж нийтдээ 130 тэрбум төгрөгөөр буюу 7.2%-иар буурсан байна. 2012 он гарсаар Европын өрийн хямрал улам даамжирч байгаатай холбоотойгоор олон улсын хөрөнгийн захууд бүгд уналттай байгаа нь мөн манай дотоодын захад нөлөөлж байна. Өнгөрсөн онд Засгийн Газрын 74.5 орчим тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бол хувьцааны арилжааны дун 3.2 тэрбум төгрөгт хүрч, нийтдээ 77.8 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн. Энэ нь 2012 оны нийт 1.1 тэрбум төгрөгийн арилжаанаас даруй 70 дахин их үзүүлэлт юм.

Зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын 2014 оны хувьцааны арилжааны дунд эзлэх хувиар авч үзвэл БиДиСек ХК нийт зах зээлийн 32%, Ти Ди



"Евразия Капитал Холдинг" ХК-ийн ногж хувьшаны ханшиний усилго

Би капитал 20%, Тулгат чандмань баян ХХК 8%, Тэнгэр капитал ХХК 7%, Евразия Капитал Холдинг 1%-ийг эзэлж байна.



**Б. Хөрөнгийн зах зээлийн түлгамдаж буй  
асуудлууд болон боломжууд**

Бусад хөрөнгийн зах зээлүүдтэй харьцуулахад Монголын хөрөнгийн зах зээлд дараах давуу тал болон боломжуул байна. Үүнд:



- Монгол улс уул уурхайн асар их нөөцтэй (ялангуяа нүүрс, эс, алт гэх мэт) учраас энэ салбартай тулгуурлан хөгжих боломжтой. Уул уурхайн салбарын осолт бусад салбаруудад мөн нөлөө үзүүлнэ.
- Зах зээлийн үнэлгээ ДНБ-ий харьцаа 10.25% байгаа боловч нь үндэсний ихэнх томоохон компаниуд хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргаагүй байгаа нь нөлөөлдөг. Эдгээр компаниуд олон нийтэд хувьцаагаа нээлттэй зарснаар хөрөнгийн зах зээл осох асар их боломжтой.
- Одоогийн байдлаар банкны зээл дотоодын компаниудын санхүүжилтийн 90-95%-ийг бүрдүүлж байна. Дотоодын банкуудын зээлийн хүү буурахгүй байгаа нь компаниудад хувд дарамт болж байгаа бөгөөд өөр хямд ортогтэй эх үүсвэр хайх шаардлагыг үүсгэж байна. Тиймээс цаашид хөрөнгийн биржид хувьцаагаа гаргах сонирхолтой компаниудын тоо эрэ осох магадлалтай.

Эдгээр боломжуудыг алдахгүй байхын тулд бусад Нээгдэж буй болон Фронтиер зах зээлүүдтэй өрсөлдж гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд хөрөнгийн зах зээлийн макро болон микро орчинд сайжруулах, шинээр хийх ёстой олон зүйл байгааг олон улсын хөрөнгө оруулагчид байнга сануулдаг. Үүнд:

- Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих урамшууллын механизмыг төрөөс хэрэгжүүлэх.
- Аж ахуйн изгжуудийн компанийн засаглалыг сайжруулах, санхүүгийн ил тод байдлыг сайжруулах.
- Хууль эрх зүйн орчинг тогтвортой байлгах. Ялангуяа татварын орчинг тогтвортой байлгах.
- Томоохон уул уурхайн төслүүд дээр баримтлах хууль эрхзүйн орчинг тодорхой болгох.

**В. Хөрөнгийн зах зээлийн SWOT шинжилгээ**

Монголын хөрөнгийн зах зээлийн багтаамж буюу хөрвөх чадвар бага байгаа нь томоохон сул тал болж байна. Зах зээлийн үнэлгээ бага, зах зээлд



"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьцааны ханшийн үнэлгээ

-8-

оролцогчид цөөн, арилжагдаж буй үнэт цааснууд бодитой санхүүгийн үнэлгээнд суурилаагүй зэрэг нь мөн сул тал болно.

Бусад шинээр хөгжиж буй Фронтиер зах зээлүүд орчин үеийн арилжааны систем нэвтрүүлэн, шуурхай ажиллаж байгаа энэ уед Монголын хөрөнгийн бирж дорвitoй шинэчлэл хийж чадаагүй байгаа нь мөн сул тал болж байна. **cap. өдөр;**

Гэхдээ Монголын хөрөнгийн биржид асар их боломжууд байна. 2011 ондоос Лондонгийн хөрөнгийн биржтэй гэрээ байгуулсандаар дэлхийн хэмжээний туршлагыг Монгол нэвтрүүлснээр үйл ажиллагаа сайжрах боломжтой.

Зах зээлийн хэмжээгээ тэлэхийн тулд уул уурхайн компаниудыг МХБ дээр гаргах ажлыг төрөөс зохицуулж хийхгүй бол асар ихээр тэлэх боломжнийг алдах аюул байгаа.

Гадаадын хөрөнгийн зах зээл гарч байгаа компанийн хувьцааны 10 хувийг Монголын хөрөнгийн зах зээлд гаргаж байх хуулийн заалт хэрэгжихгүй байхгаа.

#### Давуу талууд

- Лондонгийн хөрөнгийн биржтэй менежментийн гэрээ байгуулсан
- Засгийн Газараас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхдээ анхааран ажиллаж байгаа
- Монголын бүх иргэд Эрдэнэс Таван Толгой компанийн хувьцаа эзэмшигч болсон, цаашид үнэт цаасны зах зээлд оролцох иргэдийн тоо ёсно

#### Сул талууд

- Зах зээлийн үнэлгээ бага
- Зах зээлд оролцогчид цөөн
- Компаниуд үнэлгээ бодитой биш
- Хөрвөх чадвар бага

#### Боломжууд

- Эдийн засаг цаашидаа хурдацтайгаар ёсне
- Төрийн мэдлийн аж ахуйн нэгжүүд хувьчлагдана
- Уул уурхайн салбарын ёсолт бусад салбарын ёсөлтийг хурдаасана

#### Аюул

- Хууль эрхзүйн орчин
- Макро эдийн засгийн орчны эрсдэлийн хүчин зүйлүүд

"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьцааны ханийн үнэлгээ

**Тав. Компанийн нэгж хувьцааны үнэлгээ**

"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьцааны ханийн тодорхойлоодоо "худалдаж авах, эсвэл худалдах шахалтад ороогүй, хөлбогдох нөхцөл байдлын талаар тодорхой мэдлэгтэй, худалдан авагч болон худалдагч нарын хооронд хувьцааг шилжүүлэх үнэ" гэсэн нөхцөлөөр тосож. **Сар өдөр**

Үнэлгээг хөрөнгийн үнэлгээний олон улсын хэмжээнд хүзүүн зөвшөөрөгдсөн стандарт болон аргуудыг /өртгийн болоу зах зээлийн, орлогын хандлагын/ кэрэглэн гүйцэтгээц.

**БҮРТГЭВ**  
**№ 1**

**A. Өртгийн хандлагын аргын үнэлгээ**

Өртгийн хандлагын аргаар тус компанийн нэгж хувьцааны ханийг тодорхойлохын тулд нэгдүгээрт өнөөгийн цэвэр хөрөнгийнх нь хэмжээг тооцох ёстой.

Цэвэр хөрөнгийн хэмжээг компанийн нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хасч тодорхойлдог.

Иймд нийт хөрөнгийн дүнд шаардлагатай зохицуулалтуудыг хийдэг бөгөөд тухайлвал: найдваргүй авлага болон хэрэгцээгүй бараа материалыг хасах, бист хөрөнгийн бүртгэлийн үнэ зах зээлийн үнэ, хангтай тохирч буй эсэхийг шалгана. Харин өр төлбөрийг бүрэн барагдуулна гэсэн нөхцөлөөр авч үздэг.

Тус компанийн 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайланг нь үндэслэн тооцоо хийв.

2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус компанийн нийт хөрөнгө 2,472,154.8 мянга, богино хугацаат өр төлбөр 804,472.3 мянга, эзэмшигчдийн өмч 1,874,229.6 мянган төгрөг тус тус байна.

2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар баталгаажуулсан үлдэгдлийг үндэс болгон менгэн хөрөнгийг үлдэгдэл болох 11,138.3 мянган төгрөгөөр, авлагын үлдэгдлийг 81,151.7 мянган төгрөгөөр авлаа.

Эргэлтийн хөрөнгийн 3.4%-ийг авлага, 95.9%-ийг бусад санхүүгийн хөрөнгө, үлдэснийг бараа материал, урьдчилсан төлсөн зардал зэрэг эзэлж байна. Найдваргүй авлага болон хэрэгцээгүй бараа, материалын үлдэгдэлгүй, бараа материал зах зээлийн үнээр бэлтгэгдсэн тул эргэлтийн хөрөнгөд ямар нэгэн тохируулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Өр төлбөрийн үлдэгдлийг санхүүгийн тайланг үндэслэн богино хугацаат өр төлбөр, өглөгийн 804,472.3 мянган төгрөгөөр авлаа.

Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа компьютер, тавилга, эд хогшил нь зах зээлийн үнээр бэлтгэгдсэн гэж үзэн дахин үнэлэх шаардлагагүй гэж үзлээ.



"Евразия Капитал Холдинг" ХК-ийн изгж хувьцааны ханшийн үнэлгээ



## Цэвэр хөрөнгийн үнэлгээ

/мян.төг/

№	Балансын зүйл	2014 он	2015.02 улирал	Үнэлсэн
	<b>A. Хөрөнгө</b>			<b>СХ</b>
	<b>Эргэлтийн хөрөнгө</b>			<b>он сар өдөр</b>
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	86657.1	111884 Р ГГГ38.3	
3	Дансны авлага	86180.2	81151.7 № 81151.7	
4	Татвар НДШ авлага	360.5	31.6	31.6
2	Бусад санхүүгийн хөрөнгө	2316092.3	2316002.9	2316002.9
5	Бараа материал	1461.5	1461.5	1461.5
6	Урьдчилж гарсан зардал	6121.5	6258.0	6258.0
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2496873.1</b>	<b>2416064.1</b>	<b>2416064.1</b>
	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
1	Үндсэн хөрөнгө	59738.1	54475.2	54475.2
2	Биет бус хөрөнгө	1906.0	1615.4	1615.4
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>61644.1</b>	<b>56090.6</b>	<b>56090.6</b>
	<b>Нийт хөрөнгө</b>	<b>2558517.2</b>	<b>2472154.8</b>	<b>2472154.8</b>
	<b>B. Өр төлбөр</b>			
	<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
1	Дансны өглөг	715971.9	744105.5	744105.5
2	Цалингийн өглөг	998.4	998.4	998.4
3	Татварын өглөг		399.0	399.0
4	ЭМНДШ-ийн өглөг	309.4	151.5	151.5
5	Бусад богин хугацаат өр төлбөр		58817.9	58817.9
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>717279.7</b>	<b>804472.3</b>	<b>804472.3</b>
	<b>В. Цэвэр хөрөнгө</b>	<b>1841237.5</b>	<b>1667682.4</b>	<b>1667682.4</b>

"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нийт хөрөнгийн дүнгээс өр, төлбөрийг хасч цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлоход цэвэр хөрөнгийн дүн нь зардлын хандлагын аргаар тооцсеноор 1,667,682.4 мянган төгрөг болов.

Цэвэр хөрөнгийн хэмжээг компанийн нийт хувьцааны тоонд хувааж нэгж хувьцааны ханшиг тодорхойлоход 734 /1,667,682.4 мян.төг : 2,270.9 мян.ш/ төгрөг болж байна.

Энэ нь компанийн үл ажиллагааны үнэ цэнийг хөрөнгө талаас нь харуулж байгаа хэрэг юм.

Өргтийн хандлагын арга гарсан бүх зардлыг бүртгэж дүгнэдэг сайн талтай боловч зах зээлийн үнэ ханшиг тусгасдагтүй сүл талтай.




"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьцааны ханшийн үнэлгээ



#### Б. Зах зээлийн хандлагын аргын үнэлгээ

Аливаа компанийн зах зээлийн үнэ, цэнэ түүний хувьцааны ханшаар тодорхойлогддог нийтлэг аргачлал байдаг. Компанийн мэдээллийн хувьцааны үнэ/нэгж хувьцаанд ногдох ашгийн харьцаа зэрэг унийн үржвэр үзүүлэлтүүдийг тодорхойлоход ашиглана. Эдгээр үржвэр үзүүлэлтээр компанийн ашгийг үржүүлж өөрийн хөрөнгийн үнэ, цөмийн баримнааг тодорхойлдог.



Энэ арга нь тухайн компанийн ижил салбарт үйл ажиллагаа явуулж буй хүчин чадлын хувьд ойролцоо, төстэй санхүүгийн үзүүлэлттэй компаниудтай харьцуулахад төстэй байна гэсэн таамаглал дээр үндэслэдэг.

Гэхдээ өнөөгийн байдлаар тус компанийтай ижил түвшний санхүүгийн үзүүлэлттэй жишиг компанийн байхгүй тул шууд хэрэглэх боломжгүй.

"Евразия Капитал Холдинг" ХК-ийн нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг.

Хувьцааны хаалтын ханш 24.33 төгрөг, 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс өмнөх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш нь 24 төгрөг тус тус байна.

2015 оны 02 дугаар сарын 13-ны өдөр 5000 ширхэг хувьцаа арилжаалагджээ. Энэ нь нэг удаа хийгдсэн арилжаа боловч цөөн биш тоогоор арилжаалагдсан байна.

№	Үзүүлэлт	Нэгж хувьцааны ханш /төг/
1	Хаалтын ханш	24.33
2	2015 оны 6-р сарын 30-аас өмнөх 6 сарын дундаж жигнэсэн дундаж ханшаар	24

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан хувьцааны зах зээлийн ханшийг сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж болох 24 төгрөгөөр тооцох боломжтой гэж үзлээ.

#### В. Орлогын хандлагын аргын үнэлгээ

Үнэлгээний орлогын хандлагын арга нь ирээдүйн мөнгөн орлогыг тооцож өнөөгийн үнийг гаргахад тохиромжтой байдаг бөгөөд ирээдүйн мөнгөн орлогын ургалыг тооцох, хорогдуулах хувийг оновчтой тогтоох гэсэн 2 үе шатнаас бүрдэнэ.

Ирээдүйн мөнгөн орлогын өнөөгийн үнэ цэнийг тооцоходоо дараах томъёог хэрэглэнэ.

V = I / R




"Евразия Капитал Холдинг" ХК-ийн изгж хувьцааны ханшийн үнэлгээ

Үүнд : V-үнэ өртөг  
 I-үйл ажиллагааны цэвэр орлого буюу цэвэр ашиг  
 R- капиталчлах хувь

Аливаа хөрөнгө оруулагч бизнесийн олон хувилбараас аль боломжтойг нь сонгохын тулд тухайн хөрөнгийн одоогийн болон ирээдүйн байсыг сонирхдог. Үүнд : үйл ажиллагааны чиглэл, эдийн засаг, бизнесийн орчин, эредэл, нэмэлт хөрөнгө оруулалт, бусад хүчин зүйлийн талаар таамагдал хийсний дараа ирээдүйд тухайн хөрөнгөөс олох цэвэр мөнгөн ургаслын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлно.

-bl-



#### 1. Орлогын тооцоо

Компани цаашдын үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөндөө ирээдүйд олох орлогын тооцоог 5 жилийн байдлаар таамаглан хийжээ. Бид энхүү бизнес төлөвлөгөөний үзүүлэлтүүдийг үнэлгээндээ авч ашиглав.

2014 онд 7,165.2 мянган төгрөгний борлуулалтын орлоготой, 233,504.0 мянган төгрөгний алдагдалтай, 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 6,522.1 мянган төгрөгийн борлуулалтын орлоготой, 97,700.0 мянган төгрөгний алдагдалтай ажиллажээ.

#### Зардал үр ашгийн тооцоо

/мян.төг/

№		Төсөл				
		2016	2017	2018	2019	2020
1	Нийт орлого	200,968.4	700,858.0	1,087,270.4	1,526,253.2	2,254,140.0
2	Цалингийн Зардал	72,232.0	146,666.7	246,597.8	271,166.1	330,661.8
	Нийгмийн даатгалд төлсөн	7,945.5	16,133.3	27,125.8	29,828.3	36,372.8
	Түрээсийн Зардал	8,025.8	14,666.7	16,439.9	18,077.7	22,044.1
	Зар сургалчилгааны зардал	1,672.0	3,055.6	3,425.0	3,766.2	4,592.5
	Интернетийн төлбөр	1,003.2	1,833.3	2,055.0	2,259.7	2,755.5
	Шуудан холбооны зардал	668.8	1,222.2	1,370.0	1,506.5	1,837.0
	СЗХ-д төлөх холс	12,405.5	39,408.0	62,832.5	89,353.2	133,104.2
	ҮЦТТТХТ-д төлөх шимтгэл	9,669.8	34,089.6	51,561.2	71,068.4	103,512.6
	МХБ-ийн гишүүний хураамж	836.0	1,527.8	1,712.5	1,883.1	2,296.3
	МХБ-ийн 0.5% шимтгэл	10,072.7	35,510.0	53,709.5	74,029.6	107,825.6
	Тээврийн зардал	501.6	1,222.2	1,712.5	2,259.7	2,755.5

## "Евразия Капитал Холдинг" ХК-ийн ижж хувьцааны ханшний үнэлгээ

Сургалтын зардал	668.8	1,527.8	2,055.0	2,636.3	3,674.0
Бусад зардал	-	1,672.0	3,055.6	3,425.0	3,766.3 4,592.5
3 Зардлын дун	125,701.8	296,863.3	470,596.4	567,834.9	751,432.0
4 Татвар төлөхийн омнох ашиг	75,266.6	403,994.7	616,674.0	958,418.3	1,502,708.0
5 Орлогын албан татвар	7,526.66	40,399.5	61,667.4	95,841.8	150,220.8
6 Татварын дараах ашиг	67,739.9	363,595.3	555,006.6	862,576.5	1,352,437.2

-13-

## 2. Хорогдуулах хувийн тооцоо

Хорогдуулах хувийг тооцдог хэд хэдэн аргуул байдаг бөгөөд, тухайлбал жигнэсэн дундаж (WACC), бодит хөрөнгийг үнэлэх загвар (CAPM), нийлбэрийн аргаар тооцох (BUILD-UP) зэрэг болно.

Хорогдуулах хувийг бид нийлбэрийн аргаар тооцов. Энхүү хорогдуулах хувь нь эрдэлгүй хувь, компанийн зах зээлд эзлэх хэмжээ, санхүүгийн бүтэц, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, хэрэглэгчийн тоо, зах зээлийн өрсөлтөөн, удирдлагын менежмент, ашиг таамаглах боломж болон бусад эрдэлээс хамаардаг. Эрдэлгүй хувийг Монгол банкны бодлогын хүү 10.5%-иар тооцов. Бусад эрдэлийг 1-3% байна гэж үзлээ.

## Хорогдуулах хувийг нийлбэрийн аргаар тооцсон байдал

Эрдэлгүй хувь	10.5	Эрдэлгүй хувийг Монгол банкны бодлогын хүүтээр тооцов.
Зах зээлд эзлэх хувь	3	2014 оны байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр түйцэтгэсэн арилжааны 1%-ийг эзэлж байгаа
Компанийн менежмент удирдлагын риск	1	Удирдлагын чадварлаг багтай тул эрдлийг багаар тооцов.
